

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-47

-
1. *Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./*
- 3-47

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 22-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 18 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батбаяр, Д.Батлут, Д.Энхтүвшин;
Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, С.Лүндэг, Д.Пүрэвдаваа.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Аудитын менежер Л.Мөнхцацрал, ахлах аудитор Ж.Мөнхбилгүүн, Г.Оюунтөгөлдөр, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Сумъяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Н.Нямхүү, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Бадамсүрэн, Г.Очирбат, Л.Мөнхбаясгалан, М.Энхцэцэг, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа, Ж.Золжаргал, Д.Энхтуяа, Д.Жаргалсайхан, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 51 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их Засаг” танхим,
13 цаг 18 минут

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

С.Ганбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ирц бүрдсэн байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 59.1 хувьтай, 13 гишүүн ирсэн байна. Ирцийн мэдээг та бүхэнд танилцуулъя.

Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. С.Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна. Ганзориг гишүүн ирсэн байна. Даваасүрэн гишүүн 4 дүгээр тойрог ирсэн байна. Жангабыл гишүүн 3 дугаар тойрог ирсэн байна. Д.Жаргалсайхан гишүүн 1 дүгээр тойрог ирсэн байна. Г.Лувсанжамц гишүүн ирсэн байна. Л.Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. 7 дугаар тойрог. Г.Очирбат гишүүн ирсэн байна. Б.Пунсалмаа гишүүн ирсэн байна. Б.Тулга гишүүн ирсэн байна. 5 дугаар тойрог. Б.Уянга гишүүн ирсэн байна. М.Энхцэцэг гишүүн ирсэн байна. Ингээд ирц 59.1 хувьтайгаар өнөөдрийн хуралдааныг эхлүүлэхээр боллоо. Нээснийг мэдэгдье.

Ингээд хэлэлцэх асуудлаа та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, Төсвийн байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлнэ/.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Туваан сайд.

С.Ганбаатар: Туваан сайд оролцох ёстой шүү дээ. Ажлын хэсэг бүгдийг нь танилцуулна. Ажлын хэсэг гаднаас орж ирнэ.

Л.Мөнхбаясгалан:

Алтаниширээгийн газрын тосны үйлдвэр дээр Энэтхэгийн Эксим банкнаас нэмэлт зээл авах гэж байгаа асуудлаар бас сонсмоор байна. Тэр талаар ярилцмаар байна.

С.Ганбаатар: Тэр дээр одоо бол яг төсөвтэй холбогдуулаад та бүгдийг нь асуух ёстой шүү. Асуух болно. Саяынх бол яг энэ хэлэлцүүлэг асууж байх явцад шууд асуугаад явчихна шүү. Тэгээд нэмж энэ Төсвийн тухай хууль болон саяын ярьсан зүйлтэй холбогдуулж нэмж санал байхгүй бол өөр санал байхгүйгээр хэлэлцэх асуудлаа баталъя.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулж ирье. Ажлын хэсгийнхэн бүгдээрээ ороод, суудлаа эзлээрэй. Мөнхбаясгалан гишүүний асууснаар Туваан гишүүн байх ёстой. Энхбаяр гишүүн сайд ирчихсэн байна. Туваан сайд ирэх ёстой. Жавхлан сайд ирэх ёстой. Аудитынхан ирэх ёстой. Өөр хүмүүс байна уу. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат. Ганбат ирсэн байна уу. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Золбоо. Энэ хүмүүс ирээгүй байгаа юм уу. Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд. Бүгдээрээ байхгүй байна шүү дээ. Санжаадорж дарга орж ирж байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал дарга байна. Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх. Батмөнх дарга байна уу. Орж ирнэ биз дээ. Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг. Үндэсний аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Самбууням дарга түрүүн орж ирж байсан. Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг, Наранчимэг дарга байна уу. Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор. Дуудаарай. Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Мөнхцацрал ирсэн байна. Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа. Байнгын хороо, гишүүдийг хүндэтгэнэ шүү. Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсүх, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Ж.Мөнхбилгүүн ирсэн байна. Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Г.Оюунтөгөлдөр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан сайд ирсэн үү. Хаана хуралтай байгаа юм дуудаач. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, хөрөнгийн

удирдлагын хэлтсийн дарга Баярмандал. Энийгээ янзлаарай. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Сүхбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Дондогдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Гэрэлзаяа, Суудлаа эзлээрэй. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд. Батболд байна уу. Зам, тээврийн яамны Авто зам бодлого зохицуулалтын газрын дарга Сугармаа. Манай Байнгын хорооноос энэ хүмүүсийг дуудаарай. Яах вэ хуралдаан давхцаж байгааг ойлгож байна. Тэгэхдээ л гишүүдийг хүндэтгэнэ шүү. Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Сумьяа. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Нямхүү. Энэ яамдаас яагаад хэлтсийн дарга хүртэл ингээд явдаг юм. Нөгөө сайд нь, төрийн нарийн нь, дэд сайд нь ядаж орж ирэх ёстой биз дээ энэ чинь. Дэд сайд байхгүй. Тэгвэл энэ чинь ингэж болдог юм уу. Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Даваадалай ирсэн байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын

газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Энхжин. Ингээд бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Ингээд танилцуулж байх явцад зарим хурал давхцаж байгаа хурлаас орж ирнэ гэж. Асуулт асуух үед бүгд байгаарай.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн өдрийн мэндийг айлтгая.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар ийнхүү өнөөдөр хэлэлцүүлж байна.

Ирэх 2025 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас төсвийн бодлогыг бүсчилсэн хөгжилд зайлиггүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс ялгаатай юм.

Шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих томоохон төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж, хувийн

хэвшлийг дэмжихэд чиглэсэн 2025 оны төсөвт аж үйлдвэржилтийг дэмжих чиглэлээр тусгасан онцлог арга хэмжээг дурдвал:

1.Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн импортын гаалийн татварыг хөнгөлж, нэмүү өртөг шингээн үйлдвэрлэл эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ. Шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлтийн зорилтын хүрээнд ирэх оноос дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн бүтээгдэхүүнээ хөгжүүлж байгаа боловсруулах үйлдвэрүүдийг салбар харгалзахгүйгээр татварын бодлогоор дэмжинэ.

2.Эрчим хүчний үнэ тарифыг шинэчлэлийг үргэлжлүүлнэ. Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгжүүдээс хэрэглэгчдэд бол борлуулах, эрчим хүчний үнэ тарифыг алдагдалгүй цаашилаад ашигтай түвшинд хүргэснээр эрчим хүчний салбарын найдвартай байдал хангагдаж хөгжих бололцоо бүрдэнэ. Тарифын өөрчлөлттэй уялдаж төсвийн байгууллагын цахилгаан, халаалтын зардал нэмэгдэх боловч эрчим хүч, дулааны зохистой хэрэглээг нэвтрүүлэх, хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх шаардлагатай.

3.Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг үргэлжлүүлнэ. Жилд 1,5 сая тонн түүхий тос боловсруулж 8 дотоодын хэрэглээний 80 хувийг хангах үндэсний үйлдвэр бий болох ба шинээр 700 гаруй ажлын байр нэмэгдэнэ. Төслийн ажлын 2025 онд санхүүжих гүйцэтгэлтэй уялдуулан 450 тэрбум төгрөгийг 2025 оны төсвийн төсөлд тусгалаа.

Монгол Улсын 25 оны төсвийн тухай хуулийн төсөлд туссан бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр ирэх онд 83 сая тонн нүүрс, 1,8 сая тонн зэсийн баяжмал экспортлож, гадаад худалдааны нийт эргэлтийг 32,8 тэрбум долларт, эдийн засгийн өсөлтийг 8 хувьд

хүргээж, нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээг 36,8 их наяд төгрөгт хүргэхээр тооцлоо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн ишидвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Ганбаатар: Болдын Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууням танилцуулна.

Я.Самбууням: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн, аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлээ.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан

эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг ишидвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформыг эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэхэд зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлогыг 33 их наяд 864,7 тэрбум буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35.6 хувь, нийт зарлагыг 35 их наяд 795,2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.7 хувь, төсвийн суурь тэнцлийг 1 их наяд 909,5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1 их наяд 930,5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ.

Үүнд: Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдын төвлөрүүлэх орлогыг 0, 2025 оны төсвийн төслийг 494,3 тэрбум төгрөг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төвлөрүүлэх орлогыг 412,8 тэрбум, зардлыг 70.8, Зам, тээврийн сайдын орлогыг 110,7 тэрбум, зарлагыг 1 их наяд 645,6 тэрбум, Эрчим хүчний сайдын нийт зарлагыг 315,2 тэрбум, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төвлөрүүлэх орлогыг 54,2 тэрбум, нийт зарлагыг 904,7 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны төвлөрүүлэх орлогын хэмжээг

2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын Ашигт малтмал, газрын тосны төвлөрүүлэх орлогыг 52,6 тэрбум төгрөгөөр, Зам, тээврийн сайдын өөрийн орлогыг 5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсөвт төвлөрүүлэх орлогыг 0,4 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөжээ.

Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 902,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна.

Үүнд: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын урсгал зардлын төсвийг 56,5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 101,1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөнд хувийн хэвшилд олгох татаасыг татаасны зардлыг нэмж төлөвлөсөн нь голлон нөлөөлсөн байна. Хөрөнгө оруулалтын төсвийг улсын төсвөөс 54 төсөл арга хэмжээнд нийт 388,1 тэрбум төгрөгийг, гадаад зээл тусламжаар 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 354,4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын урсгал зардлын төсвийг 7,8 тэрбум төгрөг төгрөгөөр нэмэгдүүлэн, 29,6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөнд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,7 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын урсгал шилжүүлгийг 3,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон нөлөөлжээ.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсвийг нэг төсөл арга хэмжээнд нийт 1,2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс нэг төсөл арга хэмжээнд 449,9 тэрбум төгрөгийг гадаад зээл тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.Зам, тээврийн сайдын урсгал зардлын төсвийг 1,4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 25,8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 0,6 тэрбум төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 0,7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төсвийг 109 төсөл арга хэмжээнд нийт 1 их наяд 494,2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 9 төсөл, арга хэмжээнд 132,1 тэрбум төгрөгийг гадаад зээл тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

5 дугаарт Эрчим хүчний сайдын урсгал зардлын төсвийг 126,3 тэрбум төгрөгөөр бууруулж, 115,8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь төрийн өмчийн байгууллагуудад олгох татаасыг бууруулсантай холбоотой байна. Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсвийг 37 төсөл, арга хэмжээнд нийт 199,4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 19 төсөл арга хэмжээнд 361,8 тэрбум төгрөгийг гадаад зээл тусламжаар санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

7.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын урсгал зардлын төсвийг 221,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 777,5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 7,2 тэрбум төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 6,4 тэрбум төгрөгөөр, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 217,4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон нөлөөлжээ.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсвийг 17 төсөл арга хэмжээнд нийт 44,9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс 7 төсөл арга хэмжээнд 27,6 тэрбум төгрөгийг гадаад зээл тусламжаар санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан байна гэж дүгнэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаар товч танилцуулгыг бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. М.Энхцэцэг гишүүнээр тасаллаа. Ингээд Мөнхтулга гишүүн асуулт. Энэ нөгөө ирцийн дарааллаар явчхаж байгаа байх. Ингээд Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Баярлалаа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхнаас асуулт асууя.

2025 оны төсвийн жилд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхан олборлолт уул уурхай гэсэн хөтөлбөрийг б зорилттой хэрэгжүүлэх гэж байгаа юм байна. Энэ дээр эхний асуулт болохоороо ер нь одоо манай дээр хүчинтэй байгаа хайгуулын тусгай зөвшөөрөл болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо нь хэд байгаа. Тэд нараас хэд нь ер нь “Х” тайлан өгч байна буюу үйл ажиллагаа явуулахгүй байна вэ. Энэ талаар мэдээлэл өгнө үү.

Хоёрдугаарх нь болохоор ашигт малтмалын ордуудын ашиглалтыг нэмэгдүүлнэ гэсэн зорилт оржээ. Энэ дээр ордын тоо хэмжээг хэлээд байна уу эсвэл олборлож байгаа ашигт малтмалын тоо хэмжээг хэлсэн байгаа юу.

Гуравдугаарх нь орон нутагт салбар нэгжүүдийг Ашигт малтмал,

газрын тосны газар дээр түшиглээд байгуулж байгаа. Тэгээд энэ дээр яг тусгайлаад тэчнээн төгрөгийн төсөв тавьсан байгаа гэдэг мэдээллийг танилцуулаад өгөөрэй. Орон нутгийн салбар нэгжүүдээ ер нь бэхжүүлэх нь их чухал байгаад байгаа. Тэгээд орон нутгийн салбар нэгжүүдийн хүн хүчний асуудлаар бас тодорхой мэдээлэл өгвөл их сайн байна.

Урсгал зардлын өөрчлөлтөд гол нөлөө үзүүлж байгаа гэдэг дээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж дээр 2 судалгаа байгаа юм байна. Үйлдвэрлэл технологийн паркийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа гээд. Энэ дээр яг нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийн судалгаа өмнө нь хийгдсэн туршилага манай дээр ямар байгаа вэ. Яг судалгааг нь хийх хүн хүч бас байгаа байх. Энэ дээр нэмэлт мэдээлэл авъя. Мөн үйлдвэр технологийн паркийн цахим мэдээллийн сангийн программ хангамжийг боловсруулна гэсэн байна. Цахим хөгжлийн яамтай хэрхэн хамтарч ажиллаж байгаа вэ. Аж үйлдвэрийн яамныхнаас ийм асуултууд байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас болохоор байр ашиглалттай холбоотой зардал нь 2024 онтой харьцуулахад 2025 он нь бас нэлээдгүй өссөн юм байна. Тайлбар дээр байгууллагуудын түли, халаалт, эрчим хүч, гэрэл цахилгааны төлбөр нэмэгдэхээр байна гэсэн байна. Энэ дээр нэмэлт тайлбар авъя.

Хоёрдугаарх нь болохоороо хүнс Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан дээр тавигдсан төсвийн зарцуулалтыг харахад Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх 2024 онд 0, 2025 онд бас 0 гэж тавигдаад, ер нь энэ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан ямар явцтай явж байгаа бол. 2025 онд ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа вэ.

С.Ганбаатар: Эхлээд Аж үйдвэр, эрдэс баялгийн яам хариулах байх шүү. Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Уянга гишүүний асуултад хариулъя. Ашигт малтмал газрын тосны Хэрэг эрхлэх газар дээр яг одоо бүртгэлтэй “Х” лицензтэй 1001 аж ахуйн нэгж байгаа. “А” лицензтэй 1729 аж ахуйн нэгж байгаа. Тэгээд энэ дээр яг тодорхой “Х” тайлан өгсөн тоог нь манайхан бэлдэж байгаарай гэдгийг хэлье.

Дараагийн асуулт нь ашигт малтмалын ашиглалт олборлолтыг нэмэгдүүлнэ гээд. Энэ дээр бид нар бол мэдээж уул уурхайн салбарын яг эрэмбэ дараалал буюу хайгуул, олборлолт, ашиглалт, үйлдвэрлэл гэсэн энэ дараалал руу оруулж явах ийм бодлого хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Тэгээд энэ дээр бол шинэ шинэ хайгуулын лицензийн олголтыг дахин шинэ журмаар эхлүүлж энэ ордтой болох чиглэл рүүгээ бас үйл ажиллагаагаа явуулна. Тэгэхээр ордын тоог бас нэмэгдүүлэх, мөн одоо ашиглаж байгаа ордуудынхаа ашигт үйлийн коэффициентийг нэмэгдүүлж, эндээс олох орлого авч байгаа бүтээгдэхүүнийхээ тоо хэмжээг нэмэгдүүлэх. Тэгэхээр аль алиныг нь зэрэгцүүлээд ингээд явна гэж гэж хариулъя.

Манай дээр энэ Ашигт малтмал, газрын тосны газар дээр орон нутгийн асуудал хариуцсан газар байгаа. Тэгээд энэ газар маань одоогоор 7 аймаг дээр салбартай ажиллаж байгаа. Энэ бол бас яг энэ голчлон уул уурхайн ашиглалт явуулж байгаа, олборлолт явуулж байгаа ийм газрууд дээрээ байгаа. Тэгэхээр энэ тоогоо бид бүхэн бас нэмэгдүүлмээр байгаа юм. Яг энэ гол Монгол Улсын эдийн засагт оруулж байгаа экспортыг голлон эзэлж байгаа энэ салбарын хувьд орон нутагт хөлгүй, салбаргүй нэг салбарын хяналтын байцаагч гэсэн ийм л тоонд хязгаарлагдаад байгаа. Тэгэхээр

энэ дээр бол бас санхүүгийн асуудлууд байгаа гэдгийг хэлье.

Үйлдвэр технологийн паркийн тухай хууль өнгөрсөн парламентын хугацаанд батлагдсан. Монгол Улс яг ирээдүйдээ энэ Аж үйлдвэр нэрээ урдаа авсан нь энэ аж үйлдвэрийнхээ бодлогыг нэг номерт нь тавьж явах ийм зорилготой. Тэгэхээр энэ зорилгодоо хүрэхийн тулд хууль, эрх зүй нь бол бид нарт үйлдвэр технологийн паркийн хуулийг барьж явах ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ байдлаар төрийн тодорхой ордуудыг буюу 6 байршилд төрийн өмчийн оролцоотой компаниудыг түшиглэсэн үйлдвэр технологийн парк мөн хувийн тухайлах юм бол Алтаниширээт, Гэрэлт наран гэх мэт энэ хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалттай үйлдвэр технологийн паркуудыг цааши нь ингээд зөвшөөрлүүдийг нь өгөөд ингээд цаашаа явуулна. Энэ дээр бол хийгдсэн судалгаанууд бол нийгэм, эдийн засгийн үндэслэлийг нь тооцоолсон нарийн судалгаанууд бол байгаа. Мөн цаашидаа дахин энэ судалгааг эрчимжүүлэн хийх шаардлагатай. Бид бүхэн яг оновчтой байрлал дээр маш сайн судалгаатайгаар энэ асуудлуудыг оруулах учраас энэ зүйл дээр бид нар бас багахан санхүүжилтийг тавьж өгсөн байгаа.

Мөн Цахим хөгжлийн яамтай энэ үйлдвэр технологийн паркийн цахим мэдээллийн сангийн программ хангамжийн асуудал дээр хамтран ажиллахаар 2 сайдын түвшинд ярилцаад, ажиллагаануудаа хийгээд явж байгаа гэдэг мэдээллийг өгье.

С.Ганбаатар: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр.

Ж.Энхбаяр: Асуултад хариулъя. Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр 2023 онд төсөв тавигдаагүй, 2024 онд тавигдаагүй, 2025 онд тавигдаагүй байна гэдэг нь Жижиг, дунд үйлдвэрийн газар маань 2006 оноос анх Монгол Улс

жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх нь зүйтэй гээд бодлого гараад, улсын төсөв, хөгжлийн банк гээд нийт 800 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр олгож, ингээд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого хэрэгжиж эхэлсэн. Өнөөгийн байдлаар бол улсын төсөв, Хөгжлийн банк болон бусад олон улсын байгууллагын татан төвлөрүүлсэн бүх зээлүүд нь 100 хувь эргэн төлөгдсөн. Жижиг, дунд үйлдвэрийн сан ямар нэгэн гадна талдаа өр төлбөр байхгүй. Одоо дотооддоо 200 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж чадсан. Энэ 200 тэрбумын эх үүсвэрээрээ жилдээ эргэн төлөлтөөс нь 23-27 тэрбум дотор дахин зээл өгөх маягаар жижиг, дунд үйлдвэрээ дэмжсэн хэлбэр дээр явж байгаа. Өмнө.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайдад дахиад хугацааг нь сунгаад өгнө үү.

Ж.Энхбаяр: Ингээд улсын хэмжээнд өнгөрсөн жил гэхэд 23 тэрбум төгрөгийн эх үүсвэр нийт 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгогдсон. 2025 оны тооцооллоор бас 25 орчим тэрбум төгрөг эргэн төлөлтөөр л олгогдох хэмжээнд өөрөө өөрийгөө санхүүжүүлээд улсын төсөвт ямар нэгэн ачаалал үүсэхгүйгээр явж байгаа. Ийм байна.

Байр ашиглалтын зардалтай холбоотойгоор 21 аймгийн Хөдөө аж ахуйн газар, 21 аймгийн Мал эмнэлгийн газар яамны төсөв дээр сууж орж ирж байгаа. Үүнтэй холбоотойгоор урсгал болон ашиглалтын төсөв орон байрны төсөв нэмэгдсэн харагдаж байгаа.

Ж.Энхбаяр: Хуучин жишигээр Мал эмнэлгийн газар гэдэг маань орон нутгийн хэмжээнд байсан бол одоо босоо агентлагийн харьяа. Хөдөө аж ахуйн газруудын төсөв нь бас яамны төсөв дээр сууж өгч байгаа. Ингээд явж байгаа ажил. Урьд нь тийм биш. Орон нутгийн хэмжээнд шийдээд явж байсан

С.Ганбаатар: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Тэр “Х” тайлан ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл дээр өгч байгаа тоо нь бэлэн биш байж байж магадгүй. Бэлдээгүй байх. Гэхдээ зүгээр нөгөө уул уурхай, аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарыг цааш нь ингээд тусгай зөвшөөрөл олголт олголтыг дэмжих байдлаар өргөжүүлээд явахад нөгөө тусгай зөвшөөрлийн тоо тийм их хамаатай биш. “Х” тайлан өгч байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нь хамаатай. Мөн талбайд газар нутаг дээр хэчнээн хэмжээний талбайг хамарч байгаа нь бас их хамаатай байдаг. Тэгэхээр энэ талаараа бас дэлгэрүүлж цааш нь ярьж өгвөл “Х” тайлан өгнө гэдэг бол үйл ажиллагаа явахгүй байна гэсэн утгатай. Тэгэхээр ер нь санаж байгаагаар бол бараг л 80 хувь нь явахгүй байгаа. Тэгэхээр энийгээ тодруулаад та бүгдийг хариулчих болов уу гэж бодсон юм. Тэгээд холбогдох мэдээллийг энэ сайтаас нь харж болж байж магадгүй. Баярлалаа.

С.Ганбаатар: Туваан сайд тодруулж хариулъя. Сайд нар их тодорхой, товч хариулбал их сайн байгаа шүү.

Ц.Туваан: Уянга гишүүн бол манай яаманд бас дэд сайдаар ажиллаж байсан учраас бид нар тодорхой мэдээллүүд, бас харилцаа байгаа учраас тодорхой зүйлийг дараа нь өгье. 1729 ашиглалтын лицензтэй компаниудаас 380 компани яг өнөөдрийн байдлаар тайлангаа өгөөд явж байгаа. Бусад компаниуд бол “Х” тайлан өгөөд явж байгаа. Тэгэхээр саяхан ковидын асуудал, дээрээс нь хөрөнгө оруулалтын асуудлууд хүндэрсэн гээд энэ сэргэлт жоохон удаан байгаа. Тэгэхээр бид бүхэн бас энэ дээр дэмжих тал дээр нь хамтарч ажиллана.

С.Ганбаатар: Асуултад хариуллаа. Тэгээд бүр нарийвчилж тодорхой зүйлүүдээ бол Уянга гишүүнд бичгээр

өгнө гэж ойлголоо шүү. Ингээд дараагийн гишүүн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Эрдэс баялгийн сайдаас 3 чиглэлээр асуулт асууя.

Олборлолтын сөрөг нөлөөллөөс иргэдэд болон байгаль эх дэлхийд учирч байгаа өвдөлтийг яаж оношилж байгаа вэ гэдэгтэй холбоотой. Тэгэхээр 1 дүгээрт энэ лиценз эзэмшигчдэд тийм сургалт явуулах үйл ажиллагаа ер нь явагддаг уу. Яг үнэндээ орон нутагт бол юу ч мэдэхгүй, тэгээд л1 нөхөр “А4”-ийн лиценз аваад л, тэгээд л очиж ямар ч хууль, эрх зүйн мэдэхгүй, ямар дүрэм стандарт яадаг вэ гэдгийг, ямар зөвшөөрөл авдаг вэ, ямар технологи хэрэглэх вэ гэдгийг ерөөсөө мэддэггүй. Тэгээд энэ дээр одоо мэс заслын эмч бол сертификаттай байна шүү дээ. Лицензтэй. Тэр шиг ингээд энэ хүмүүст ер нь энэ чиглэлээр ямар арга хэмжээ авдаг вэ. Гадаад орнууд бол шал өөр маягаар өндөр шалгууртай. Одоо бол зүгээр л дурын нэг компани мөнгөө төлсөн л бол тэгээд лиценз өгөөд явдаг. Энэ дээр ийм судалгаа хийх боломж байна уу. Олборлолтын сөрөг нөлөөлөлтэй холбоотой.

2-т нь олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа энэ бүс нутагт ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээнээс гадна нийгмийн үнэлгээ гэдэг зүйлийг заавал хийдэг олон улсад. Тэгээд энэ манайд одоог хүртэл нэвтрээгүй байгаа. Энэ дээр ер нь ямар бодлого барьж байгаа вэ. Байгальд хамгийн бага сөрөг нөлөө үзүүлэх энэ тэргүүний техник технологи байгаа. Жишээлбэл газрын тосны өрөмдлөгийг ингэж зөвхөн босоо биш налуу өрөмддөг технологи нэвтрээд олон жил болж байгаа юм. Олон оронд газрын тосны үйлдвэрлэлд гүний цэнгэг усыг ашиглахыг бүр тас хориглочихсон. Тэгээд манайд бол хамгийн хямд аргаар ингээд олборлоод яваад байгаа юм. Сүүлдээ энэ Мэнэнгийн тал чинь Мэнэнгийн цөл болох вий. Арабд бол бас түүх судар ном дээр

ингээд зээр гөрөөстэй байсан гэж байдаг юм гэнэ лээ. Би очиж үзээгүй. Мэдэхгүй. Одоо бол Арабын цөл гэж байгаа юм. Тэгэхээр би энийг эсэргүүцээд байгаа юм биш. Ашиглана хүн төрөлхтөн байгалийн баялгаа. Гэхдээ яаж хамгийн бага сөрөг нөлөөлөлтэй ашиглах вэ, гүний усыг явал ашиглахгүй байх вэ үйлдвэрлэлд, явал энэ налуу өрөмддөг технологийг нэвтрүүлэх вэ гэх зэрэг зүйл дээр судалгаа хийх ийм шаардлага байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ зардлыг энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ гээд бас нэлээн их мөнгө байгаа юм байна. Бараг тэрбум орчим төгрөг. Эндээсээ гаргах боломжтой юу.

2-т нь Хөдөө аж ахуйн сайдаас мал эмнэлгийн үйлчилгээний тарифыг өөрчлөх энэ тал дээр бодлого байгаа юу. Орон нутагт жоохон хүнд байгаа. Энэ байгалийн ургамал хадлангийн газрын төлбөр 90 хэдэн оны тарифаараа явж байгаа. Энийг өөрчлөх ийм бодлого байгаа юу. Мөн бусдаар гүйцэтгүүлэх энэ ажлын зардлаасаа өвөлжсөө хаваржааны доорх газар гүний худгийн цооногийн зөвшөөрөл олголтыг яг доод хэмжээ нь хэд байгаа юм. Аль аймагт энэ олголт нь ер нь хэтрээд байгаа юм. Яг стандарт норм байна уу. Энэ тал дээр судалгаа хийх өргөн хүрээнд бүх аймгуудад хийх боломж байна уу. Энийг энэ зардлаас гаргах боломж байна уу. Өөрөөр хэлбэл нийтдээ дүгнэж хэлэх юм бол энэ 2 зүйлийг ерөөсөө зөв оношлох хэрэгтэй байгаад байгаа юм. Бэлчээр хамгаалах, уул уурхайн сөрөг нөлөө бууруулах чиглэлээр.../минут дуусав/

С.Ганбаатар: Эхлээд Туваан сайд хариулъя. Дараа нь Энхбаяр сайд бэлдэж байгаарай.

Ц.Туваан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Мэдээж уул уурхайн олборлолт явагдаж байгаа тохиолдолд компани үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд бол мэдээж ямар нэгэн байдлаар байгалийн онгон байдлыг бол хөндөж тийм ээ, үйл ажиллагаанууд

явагдана. Тэгэхээр энэ дээр тэр иргэд болон орон нутагт очиж байгаа өвдөлтийн асуудал дээр бид нар энэ хамгийн сүүлд ер нь бол уурхайн бодлого дээр хариуцлагатай бол уурхай буюу бүх уул уурхайд оролцогч талууд нь харилцан ашигтай байх гэдэг энэ хариуцлагатай бол уурхай гэдэг кодексыг 2018 оноос мөрдөж байгаа. Энэ хүрээндээ бас судалгаануудыг хийгээд, энэ хүрээг бодлогодоо баримталж ажиллах ийм чиглэлийг хэрэгжүүлж байгаа.

Мөн хамгийн сүүлд бол бид нар Канадын ахисан түвшний кодексыг авч судалгааг авч гэрээ байгуулаад энэ төрлийн судалгаагаа үргэлжлүүлэн хийх асуудал дээрээ бол хандаж байгаа гэдгийг хэлье. Мэдээж бид нар үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал газрын тосны салбар өөрөө. Дээрээс нь манай улс нефть бүтээгдэхүүнийхээ 95, 96 хувийг нэг улсаас хараат бүгдийг нь импортоор авдаг. Тэгэхээр энэ дээр бол бид нар газрын тосны үйлдвэр Монгол Улс 1,6 тэрбум долларын нэмэгдсэн дүнгээр зээл аваад энэ салбараа хөгжүүлэх гээд ингээд явж байгаа. Энэ нь өөрөө үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Тэгэхээр бид нар энэ дээр бас энэ газрын тосны түүхий нефт, түүхий тосны олборлолтын хэмжээг зайлшгүй нэмэгдүүлж гаднаас худалдаж авах биш дотоодоосоо бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд энэ тосоо хангах зорилго тавиад явж байгаа. Тэгэхээр энэ дээр бас бид нар цаашид нь үйл ажиллагаагаа нэлээн жоохон тэлэх ийм бодлого явуулна. Энэ дээр бас яг манай газрын тосны үйл ажиллагааны 90 хувь явж байгаа Дорнод аймгаас сонгогдсон Бадамсүрэн гишүүнтэй бол бас нягт хамтарч орон нутагтайгаа хамтарч иргэдтэйгээ ойлголцож ингээд ажиллана гэдгийг хэлье.

Би саяхан бас энэ Петрочайна Дачин тамсаг компанийн газар дээр нь очиж ажиллаад ирсэн. Энэ хүрээндээ бас тэр орон нутгийн удирдлагуудтай ч уулзсан, иргэдийн төлөөлөлтэй ч уулзсан,

тэнд ажиллаж байгаа ажилчидтай ч уулзсан. Тэгэхээр асуудлууд бол мэдээж байгаа. Тэр дээр нөгөө иргэний нийгмийн байгууллагынхны тавьдаг нөгөө шингэн хаягдлыг цэвэршүүлэх, дээрээс нь энэ бохирлогдсон шороог цэвэрлэх, гүний усыг нэлээн өндөр хувьтай эргүүлэн ашиглах гээд энэ асуудлууд дээр бол тодорхой ахиц дэвшилүүд бас гараад явж байгаа юм байна лээ. Тэгэхдээ мэдээж цааш нь сайжруулах асуудлууд бол нэлээн байгаа. Тэгэхээр энэ гүний усны ашиглалт, эргэн ашиглалт гэдэг дээр бол онцгой анхаарч ажиллана гэдгийг бас танд энэ ташрамд хэлье.

С.Ганбаатар: Туваан сайд хариулаа. Энхбаяр сайдын микрофон нээж өгье.

Ж.Энхбаяр: Мал эмнэлгийн үйлчилгээний асуудал. Монгол Улсын хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээ үндсэндээ хувийн хэвшилд 100 хувь шилжсэн. Сум бүрд хувийн мал эмнэлгийн байгууллага үйл ажиллагаа хийж байгаа буюу Мал эмнэлгийн ерөнхий газар аймгуудын Хөдөө аж ахуйн газартай хийсэн гэрээний үндсэн дээр явж байгаа. Энэ дээр сая энэ оны 6 сард Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яамны сайдын хамтарсан тушаал гарч, мал эмнэлгийн үйлчилгээний тарифыг 2 дахин нэмэгдүүлсэн. Энэ тарифын нэмэгдэл 9 сараас буюу намрын вакцинжуулалттай холбоотойгоор шинэ тарифаар үйлчилж эхэлнэ.

2 дугаарт хадлан, худаг усны асуудалтай холбоотойгоор. Малын хөлийн татвар гэж бид нар ярьдаг. Энэ татварыг орон нутаг өөрөө хэмжээг нь зохион байгуулж байгаа. Татварын тоо хэмжээг тааруулж байгаа.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайдад нэмж хугацаа өгье.

Ж.Энхбаяр: Орон нутаг малын хөлийн татварыг өөрөө тогтоож, өөрөө

хурааж авч, өөрөө эргэн зарцуулж байгаа. Хөдөө аж ахуйн яамны түвшинд энэ 2025 онд салбарын хэмжээнд 5,9 тэрбум төгрөгийн л хөрөнгө оруулалт байгаа. Улсын хэмжээнд. Үүнээсээ бид нар 1,6 тэрбумыг нь худаг ус гаргах энэ ажил хийгдэж байгаа. Энэ урд нь гарсан гидрогеологийн хайгуул судалгаа хийсэн газрууд дээр л хойноос нь хөөж яваа. Мэдээж хангалтгүй байгаа. Тэгээд байгаа нөөц буюу 1,6 тэрбумын хүрээнд бэлчээр усжуулах ажил хийнэ. 2025 онд хэрэгжинэ. Нөгөө талаар бэлчээрийн даац ноцтой хэтэрсэн байгаа. Нийт бараг газар нутгийн 70 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрсэн. Малын тоо толгой өндөр байгаа. Ачаалал өндөр байна. Үүнтэй холбоотойгоор бэлчээрийн нөхөн сэргээгдэх түвшин муу байна. Мал өөрөө шаардлагатай тарга хүчээ авч чадахгүй байна. Ингээд байгаль цаг уурын эрсдэлд эмзэг буюу дархлаа их унаж орж ирж байна. Өнгөрсөн он гэхэд 8-аар.../минут дуусав/

С.Ганбаатар: Нэмж хариулах уу та. Энхбаяр сайд тодруулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотойгоор малын онд оролт муу байна. 8,1 сая гэдэг маань багцаагаар тэрбум долларын бид нар боломж алдаж байгаа юм. Хөдөө аж ахуйн салбар өнгөрсөн онд 34 хувийн уналт үзүүлсэн малын тоо. Тэгэхээр бид нүүдлийн мал аж ахуйгаа эрсдэл давах чадавхтай болохын тулд яаралтай таримал тэжээлийн ургамлын массыг нэлээн сайн нэмэх, Бадамсүрэн гишүүний хэлдгээр тэр хадлангийн төлбөр, хадлангийн бүс нутгийг онцгой тогтоох, эндээ хадлангийн аж ахуйнуудыг хөгжүүлэх, бүс болгонд тэжээлийн нөөцүүдийг тэжээлийн аж ахуйнуудыг бий болгож байж нүүдлийн мал аж ахуйгаа эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх нь зайлиггүй байгаа. Тэгээд бид бол энэ бодлогын төлөө нэлээн зорьж байгаа. Мэдээж улсын төсөв хязгаарлагдмал байгаа энэ үед бид бусадэх үүсвэр, олон улсын төсөл хөтөлбөрт энэ саналаа

тусгаад тодорхой хэмжээний эх үүсвэрүүдийг шийдүүлээд явж байна.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Туваан сайд аа, би нөгөө ингэж асуугаад байгаа юм. Шинэ технологийг л нэвтрүүлэх тал дээр анхаарахгүй бол бид нар аймаар хоцрогдоод байгаа байхгүй юу. Яг үнэндээ. Ингээд магадгүй ингээд дайн тулаантай тэр зарим орнууд, тэгээд Монголд л бараг автомашинаар ингээд зөөж байгаа байх. Тэгээд энэ чинь асар хямд өртгөөр олборлож байгаа байхгүй юу. Үндэсний аюулгүй байдлыг ойлгож байгаа. Гэхдээ бид нарт үлд дэлхийн маань байгаль, эх дэлхий. Тэгэхээр Уул уурхайн яам бол стандартаа сайн тавих ёстой гэдэг зүйлийг яриад байгаа. Тэгээд энэ дээр би бас нэмж тодруулга авмаар байна.

2 дугаарт нь Энхбаяр сайдаас нөгөө эрчимжсэн, хосолсон хэлбэрээр мэдээж явах зорилт руу хөдөө аж ахуйн салбар явж байгаа учраас зарим бэлчээр ангиллыг яаж тариаланд шилжүүлэх вэ. Ийм зохистой газруудын судалгаа улсын хэмжээнд нэлээн байгаа юм байна лээ. Тэгэхгүй бол энэ шинэ хоршоо энэ тэжээлийн ургамал тариалах бодлого маань явахгүй байгаа. Одоо тариалангийн газруудын чинь хэдхэн том компани авчхаад байгаа байхгүй юу. Иргэдэд энэ маань 100 га хүртэл олгох хуулийн зохицуулалттай. Гэхдээ иргэдэд энэ маань олдохгүй байгаад байна. Яагаад гэвэл компаниуд эзэмчихсэн.../минут дуусав/

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн маш тодорхой асуулт асууж байна. Тодорхой хариулна шүү. Юу вэ гэвэл технологийн шинэчлэл өөрчлөлт орох уу. Туваан сайд.

Ц.Туваан: Бид нар бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулчихсан ч газрууд байгаа. Мөн зарлачихсан талбайнууд

байгаа. Нэмж зарлах гэж байгаа талбайнууд байгаа. Тэгэхээр түрүүн хэлсэн 1,5 сая руу эхний ээлжид хүрэхийн тулд бид нар маш хурдацтай, маш яаралтай ажиллах ийм шаардлага байгаа. Тэгэхээр бид нар нөөц тогтоосон газруудтай байгуулах бүтээгдэхүүн хуваах гэрээн дээрээ яг энэ хууль дүрмийн дагуу бүх стандартаа мөрдүүлээд явна гэдгийг бас энэ таирамд хэлье.

Мөн түрүүний таны хэлсэн хавж өрөмдөх, хөндлөн ташуу өрөмдөх энэ асуудлуудыг бол бас бид нар сүүлийн үеийн талбай аваад хайгуул хийж байгаа компаниуд ч гэсэн энэ чиглэл рүү ороод ингээд явж байгаа. Тэгэхээр мэдээж Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль болон олон улсын стандарт, дүрмүүдийг бол бид нар энэ компаниуддаа цаашидаа байгуулах гэрээндээ ягштал тусгаад ингээд хийгээд явна.

Мөн олборлолт хийж байгаа компаниуддаа ч гэсэн бид бүхэн сая хамгийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайдад нэмж хугацаа өгье.

Ц.Туваан: Сая Петровича Дачин Тамсаг компанийн толгой бүр хамгийн дээд талын компани болох Си Эн Пи Си гээд 1 сая ажилчинтай, дэлхийн нэг номерын компанийнхантай очиж уулзаад бас яг энэ стандартын асуудлыг, технологийн асуудлыг, хөрөнгө оруулалтын асуудлыг, олборлолт нэмэгдэх асуудлуудыг бас ярьж эхлээд явсан байгаа. Тэгээд нөхдүүдийн зүгээс тавьж байгаа ганцхан юм байгаа. Тэр нь Монгол Улс өөрөө өмнө нь байгуулчихсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээ мөрдөөч ээ. Битгий хажуугаар нь ингээд шинэ шинэ юм бодож олоод, асуудал гаргаж ирээч. Бид бүхэн энэ асуудал гаргаж ирэхгүй цаашидаа энэ салбарт тогтвортой хамтарч ажиллахад бэлэн гэдэг ийм яриануудыг хийгээд ирсэн. Тэгэхээр энэ ажил маань бас урагшлах байх гэж найдаж байгаа юм.

С.Ганбаатар: Асуулт нь хамгийн гол нь Дорнодын тэр байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр технологийн шинэчлэлд өөрчлөлт хийх үү л гэж асууж байна. Тэр дээр хэзээ хийх вэ, хаана, ямаршуу өөрчлөлт гарах вэ л гэж тийм тодорхой юм асуугаад байх шиг байна шүү дээ. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Гишүүн их зөв асуудал хөндлөө. Үнэхээр өнөөдөр 1,1 сая га газар хөдөө аж ахуйн яг энэ газар тариаланд ашиглагдаж байгаа юм. Энэ маань Атрын 1, 2 дугаар аяны хүрээнд эргэлтэд орсон. Тэгэхэд Монголын хүн ам 1 сая хүрээгүй байсан. Одоо хүн ам маань 3.5 сая, 2030 он гэхэд 4 сая хүрнэ. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэглээг хангахад одоо манай байгаа газар хүрэлцэхгүй болж хувирсан. Тэгэхээр бид төсөвт харвал хөдөө аж ахуйн салбарт Атрын 4 дүгээр аян гэсэн бодлого орж ирж байгаа юм. Хэрвээ энэ бодлого Их Хурлаар батлагдвал энэ бодлогын хүрээнд 200 мянга га талбайг шинээр нэмж, хөдөө аж ахуйн эргэлтэд оруулах зайлиггүй шаардлага үүснэ. Үүний бараг 100 гаруй мянга нь нөгөө шинэ хоршооллоо дэмжих, малчдаа нөгөө тэжээлийн ургамал тарих тэр зориулалтаар ашиглагдах байх. 100 мянга нь үр тариа болон бусад төрлийн экспортод чиглэсэн хүлэмжийн аж ахуй, жимсний аж ахуй, нарийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайдад хугацаа нэмж өгье.

Ж.Энхбаяр: Бусад төрлийн энэ аж ахуйг хөгжүүлэхэд чиглэнэ. Үнэхээр төвлөрлийг энэ хотын төвлөрлийг сааруулья гэвэл хөдөөгийн хөгжил л анхаарах хэрэгтэй. Хөдөө хүн ажиллах, амьдрах, орлоготой байх боломжийг бүрдүүлнэ. Ялангуяа энд бол төвийн бүс нэлээн ачаалал үүрэх бололцоотой. Энэ цаг уурын таатай газар тариалан бүс нутгаа дагаж газар олголтыг түлхүү хийгээд, аж ахуй эрхлэх сонирхолтой улсууддаа энэ газрыг нь олгох туслах аж

ахуй эрхлэх газрыг нь олгох, жимсгэнэтэй болох газрыг нь олгоод ингээд шилжилтийг цогцоор нь хийвэл нэлээн үр дүн хүрэх ийм боломж их өндөр байгаа юм. Тэгэхээр энийг бол яам тодорхойлоод энэ төсөл дээр нэлээн суулгасан. 2025 ондоо нэлээн эхлэлийн жил байх болов уу. Тэгээд үр дүн гарсан нөхцөлд 2026, 2027 онд бүгдээрээ энийг өргөжүүлээд ингээд томоохон шилжилтийг газрын харилцаатай холбоод аж ахуй эрхлэхтэй холбоод явуулчихад бол нэлээн бодитой үр дүн гарах байх. Ялангуяа Дорнодын бүс нутаг бол Монгол улсын ирээдүйн нөөц нутаг. Газар тариалангийн тэжээлийн. Тэгэхээр энд бол их том бодлого тусдаа явна. Ялангуяа энэ газрын тосны уул уурхайн асуудалтай.../минут дуусав/

С.Ганбаатар: Ойлголоо. Энэ дээр хамгийн гол нь сайд нар хариулахдаа болж өгвөл одоо чинь төсөв ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ атар газраа эзэмших гэдэг юм уу тэр газрын менежмент шинэчлэл хийхэд мөн түрүүний тэр технологийн шинэчлэл хийхэд төсөвт хэдийг тавьсан юм төсөвт энэ туссан уу гэдэг дээр хариулбал маш том буян болно. Ингээд Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Тэгээд би гол нь нөгөө төсөвтэй холбоотой энэ дээр бусдаар гүйцэтгүүлэх ажил гээд нэлээн их мөнгө байгаа байхгүй юу. Бараг 1 тэрбум төгрөг эрдэс баялгийн яаман дээр, Хөдөө аж ахуйн сайд дээр бас нэлээн их мөнгө. Тэгэхээр эндээсээ нөгөө бид нар ингээд энэ салбартаа хөгжүүлэхэд тулгамдаад байгаа асуудлуудаа зөв оношилъя. Албан тасалгааны цонхоор ингээд Улаанбаатар хотоос амьдралыг харахгүй. Яг орон нутагт яагаад сөрөг нөлөөлөлд өртөөд иргэд энийг эсэргүүцээд байгаа юм бэ, явал иргэдэд бүтээмжтэй технологи дэвшүүлэх юм бэ гэдэг зүйл дээр судалгаа хийе гээд байгаа байхгүй юу. Нийгмийн үнэлгээ хийе гэж байгаа юм. Хүнээ бодсон ийм юм гаргая.

2-т нь хөдөө аж ахуйн салбар дээр болохоор яг ийм ийм судалгаанууд хийе. Ер нь ингээд өвөлжөө, хаваржааны газрын олголт чинь ямар байгаа юм. Бэлчээрийн ашиглалт чинь ямар байгаа юм. Энэ зөвхөн нэг аймгийн хэмжээнд биш байхгүй юу. Улсын хэмжээнд ийм томоохон үр дүнтэй, даацтай судалгаа хийгээд, энэ дээрээ үндэслээд энийгээ амь оруулаад, эмнэлэгт үзүүлээд, шинжилгээ хийгээд, эм аваад тэгээд тэрийгээ уугаад идэгтэй адилхан ингээд энэ судалгаа шинжилгээгээ ашиглаад юмаа явуулъя гээд байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол энэ мэргэжилтэн болгон ингээд.../минут дуусав/

С.Ганбаатар: Сайд нар, яамдууд тухайн орон нутаг, ард иргэдтэйгээ холбогдох тэр Иргэдийн Хурал, Засаг даргатай ойлголцож ажиллах гэдэг л хамгийн чухал байна шүү. Шууд дээрээс очоод л шууд хийгээд байхаар биш. Ингээд Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Жавхлан сайд түрүүн бас мэдээлэлдээ хэлж байна. Яг манай энэ Аж үйлдвэрийн байнгын хорооны хариуцах ажилтай холбоотой жижиг, дунд үйлдвэрлэл болон дунд үйлдвэр, том үйлдвэрүүдийг дэмжиж ажиллана гээд байгаа юм. Яг яаж дэмжих вэ. Жишээ нь Монголбанкны Ерөнхийлөгчтэй уулзахад бодлогын хүүгээ бол тодорхой буулгаад, зээлийн хөшүүргийн аргаар дэмжинэ гэсэн гарц гаргалгаа бол хэлээгүй. Яг одоо бид нар дээр ирсэн байгаа мэдээллээр бол яг жижиг, дунд үйлдвэрлэлийг ингээж Хүнс, хөдөө аж ахуйн яамны Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангаар дамжуулж хэчнээн мөнгийг ингээж аж ахуйн нэгж эрхлэгч нарыгаа дэмжинэ гэсэн юм бол олж харахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр яг яаж дэмжих вэ. Татварын бодлогоор дэмжих гэж байгаа юм уу. Мөнгөний бодлогоороо дэмжих гэж байгаа юм уу гэдэг дээр нэг асуулт авчихъя.

2 дугаарт түрүүн бас яг энэ төсөвтэй холбоотой болохоор л асуугаад байгаа шүү. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр 2025 оны төсвийн төсөлд 904,7 тэрбум төгрөг тусгагдсан. 2024 оны тодотголоор батлагдсан төсвөөс 26.4 хувь 188,7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна гэж байгаа юм. Тэгэхээр тэр 188,7 тэрбум төгрөгийг яг газар тариалангийн салбарт, мал аж ахуйн салбарт Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан дээрээ байхгүй байгаад байгаа шүү дээ. Дамжуулаад хэчнээн хэмжээний аж үйлдвэрийн салбар юу гэдэг юм, хөнгөн үйлдвэрлэл дээр явж байгаа тэр сүү үйлдвэрлэж байгаа, газар тариалангийн салбар дээр газар тариалангийн үйлдвэрлэл хийж байгаа, мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ингээж ингээж дэмжинэ гэсэн ийм хариулт ийг бас авчихмаар байна.

Дараагийнх нь асуулт бол Эрдэс баялгийн яамнаас асуух гэсэн юм. Бид бол 2024-2028 онд бол хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд ийм том концепц явж байгаа. Асар их ачаалал бол Цэвэгдоржийн Туваан сайд аваад явж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр яг та энэ нөгөө алт боловсруулах үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэр, гангийн үйлдвэр дээрээ бас яг тодорхой санхүүжилт нь ингээж яваад, үр дүн нь ингээж ингээж гарах юм. Тэгснээрээ бид нар 2028 онд нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянга болгох зорилтоо биелүүлсэн юм гэсэн ийм асуултад харуулаад өгөөч. Тэгээд тодруулъя. Тэгэх үү.

С.Ганбаатар: Жавхлан сайд эхлээд хариулъя. Дараа нь Энхбаяр сайд, тэгээд Туваан сайд.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Жижиг, дунд үйлдвэрлэл, дунд үйлдвэрлэл, том бүтээн байгуулагч том үйлдвэрлэгч нар гээд ер нь аж үйлдвэржилтийн энэ салбарыг 2025 онд хэрхэн яаж дэмжиж байгаа вэ. Жишээ нь жижиг, дунд үйлдвэрлэл дээр

бид Энхбаяр сайдын ярьж байгаа эдний яам дээр тавьсан хэсэг бол зөвхөн зээлийн бүтээгдэхүүнээр дэмжих, цаана нь бид нар зах зээлээр нь дэмжих, эдийн засгийн тогтвортой байдлаар нь дэмжих, ингээд татварын бодлогоор дэмжих гээд гол яг ийм макро бодлогууд байгаа юм. Төв банкныхан байвал бас өөрсдөө хариулна биз. Яах вэ, Төв банкны энэ бодлогын хүү бол эдийн засгаа макро орчноо тогтвортой байлгах л ийм эцсийн зорилго. Эцсийн зорилго нь юм байгаа юм. Татварын бодлогын хувьд бол харин 2025 онд бид нар нэлээн дорвитой ийм бодлогын шийдлүүдийг оруулж ирж байгаа. Энийг хурал болгон дээр ярьж байгаа даа. Ер нь 3 чиглэлээр байна.

Хамгийн 1 дүгээрт бүсчилсэн хөгжлийнхөө суурь үзэл баримтлал дээр тулгуурласан бүс бүр өөрсдийнхөө давуу байдал, тэргүүлэх чиглэлүүдийгээ дэмжих, бусад бүсүүдтэйгээ кластерлах ямар боломжууд байна. Энийгээ дэмжсэн өөр өөрсдийн тусдаа ялгавартай бодлого явуулах эрх зүйн боломжийг нь нээж өгч байгаа. Энэ бол маш том ийм өөрчлөлт гарч ирж байгаа.

2 дугаарт боловсруулах чиглэлийн үйлдвэр, мөн боловсруулах шатыг ахиулах энэ чиглэлээр өмнө нь бид нар салбар салбараар нь сугалж ингээж татварын таатай орчныг бүрдүүлдэг байсан бол бол ирэх жилээс эхлээд салбараа харгалзахгүйгээр бүх салбарт энийг нэвтрүүлэх ийм томоохон алхам хийж байгаа.

2 дугаарт мөн жижиг гэлтгүй жижиг, дунд, том аль ч аж ахуйн нэгжүүд дээр яг Засгийн газрын нийгмийн чиглэлийн суурь зардлууд хөрөнгө оруулалтууд дээр бодитой ачааллыг хуваалцаад, энэ чиглэлийн спортын, соёлын, нийгмийн, уул уурхай, ногоон ногоон сэргэлтийн чиглэлийн иймэрхүү хөрөнгө оруулалтууд болон тусламж үзүүлбэл тэр хэмжээгээр нийт борлуулалтын орлогынх нь 1 хувь хүртэл татвараас хөнгөлөх, чөлөөлөх ийм 3

томоохон бодлогын татварын шинэчлэлүүдийг санал болгож оруулж байгаа. 2025 оны хууль дээр.

Дээрээс нь бид ирэх жил энэ зам, тээвэр логистикийн эрчим хүч гэж байгаа маань бол эцсийн дүндээ ерөөсөө яг үйлдвэрлэгч, баялаг бүтээгч нарыг л дэмжих л ийм л том бодлого юм байгаа юм. Энэ эрчим хүчний салбарын либералчлал ч гэсэн дээ. Ер нь бол цаашидаа бид аж үйлдвэр барья, энэ бүтээн байгуулалтуудыг тэлье, энэ боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдийг барья гэвэл бид нарын хамгийн том боомилж байгаа асуудал маань явж явж энэ эрчим хүч л болж ирж байгаа. Тийм учраас энэ эрчим хүч, зам тээврийн бүтээн байгуулалтын үзүүр дээр нь бол төр дахиад цэцэрлэг, байшин барих биш, яг баялаг бүтээгчдийн үйлдвэрлэлд баригдах өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх хөдөө аж ахуйн салбар гэлтгүй ерөөсөө уул уурхай, аялал жуулчлал, боомт, экспорт гээд бүхий л чиглэлүүд дээр яг хувийн хэвшлийг дэмжиж байгаа. Тэр дээр үр өгөөж нь гарч ирэх л ийм том бодлогын шилжилт хийж байгаа л гэж энэ төсвийн гол онцлог нь байгаа юм.

С.Ганбаатар: Дараа нь тодруулъя Очирбат гишүүн ээ. Гурвууланг нь асуучхаад дараа нь та тодруулсан нь дээр байх. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: 2025 оны төсөвт урсгал зардал нэмэгдэж харагдаж байгаа. Энэ маань юу вэ гэвэл 4 том бодлого хэрэгжиж байгаа.

1 дүгээрт “хүнсний хувьсгал”, 2 дугаарт “Цагаан алт” үндэсний хөтөлбөр, 3 дугаарт “Шинэ хоршоо” хөдөлгөөн, 4 дүгээрт “Атрын 4 дүгээр аян” гэсэн манай салбарын 4 бодлого дөрвүүлээ Их Хурал, Засгийн газрын тогтоолтойгоор ингээд төсөв хөрөнгөд суугаад, нийт 601 тэрбум төгрөг харагдаж байгаа. Энэ удаагийн онцлог нь энэ болгон мөнгө маань өөрөө бараг 6 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт буюу

эдийн засгийг хөдөлгөж байгаа. Энэ гол урсгал зардлууд зөвхөн бизнесийн зээлийн хүүг төсөв дээр суулгаж дааж байгаагаараа онцлог. Жишээлбэл, юу гэдэг юм энэ.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайдад хугацааг нь нэмж өгье.

Ж.Энхбаяр: Жишээлбэл “Цагаан алт” үндэсний хөтөлбөр дээр эргэлтийн болон хөрөнгө оруулалтын 1,5 их наядын зээл олгогдоно. Арилжааны банкнуудаас. Энийг олгуулахын тулд улсын төсөв дээр бид 304 тэрбум төгрөгийг л суулгаж байгаа юм. Арилжааны банк судалгаа хийгээд, бодлогын дэмжлэгүүд тэр зээлүүд олгогдоно. Тэрний хяналтаа хийгээд бид нар тэр зээлийн хүүгийн татаасыг манай яамаар дамжуулаад л Сангийн яамнаас олгогдоод л явж байгаа юм. Өмнө нь болохоор дарга сайд нар аль компанид зээл олгох вэ, ямар салбарт олгох вэ гээд их оролцоо ихтэй байсан байна. Энэ бол хязгаарлагдсан. Зөвхөн бодлого, үндэсний хувьсгалын хүрээнд ийм салбарыг дэмжинэ. “Цагаан алт”-ын хүрээнд ноос ноолуур, арьс ширний боловсруулалтыг энэ түвшинд нь ингэж дэмжинэ гээд түвшин болгоноор нарийн судалгаа гараад, хөтөлбөр батлагдчихсан байгаа. Энэ 5-6 жилийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа. Жишээлбэл Цагаан алт, хүнсний хувьсгал бол 5 жилийн хөтөлбөр одоо 2,5 жил нь явж байна. Ахиад 2,5 жил үргэлжилнэ. Цагаан алт 6 жилийн хөтөлбөр. Энэ жил эхэлж байна.

С.Ганбаатар: Энхбаяр сайд.

С.Ганбаатар: Тэгэхээрээ Хөдөө аж ахуйн яам бол тэр бодлогын чиглүүлэх талд нь хяналтаа тавиад, энэ зээл яг ноолууринхаа салбартаа, хөрөнгө оруулалтад нь ноосонд нь арьс ширэнд нь өгч байна уу, энэ хүнсний яг сав баглаа боодлын үйлдвэр, хүнсний үйлдвэрлэл, шугам өргөтгөж явж байна уу гэдгээ л бид нар сайн хяналт тавиад л чиглүүлээд байгаа юм. Бусад нь бол цэвэр бизнесийн

зарчмаар шийдэж байгаа. Үндсэндээ нэг төгрөг зараад энийгээ 3, 5 болгож эдийн засагт оруулах нь их зөв. Энийгээ арилжааны банк хариуцлагаа хүлээж авах нь зөв гэсэн ийм бодлого хэрэгжиж байгаа. Нөгөө тал дээр урсгал зардал дээр бас анзаарагдаж байгаа том тоо бол урамшуулал. Манай салбар 5 төрлийн урамшуулал хэрэгжиж байгаа. Ноос, арьс шир, улаан буудай, сүү, хүнсний ногоо гэсэн 5 зүйл. Энэ болгон үйлдвэрлэлд нийлүүлсэн сүү литр тутамд мянган төгрөг олгоно гэдэг юм уу, үйлдвэрт тушаасан ноос тутамд 2 мянган төгрөг олгоно гэдэг юм уу, нөгөө “Цагаан алт” хөтөлбөрөө үйлдвэрлэх, боловсруулах.../минут дуусав/

С.Ганбаатар: Баярлалаа. Туваан сайд.

Ц.Туваан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Саяхан 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан. Тэгээд мөн энэ “Хурдтай хөгжлийн төлөөх Зориг” гээд энэ том хөтөлбөр зорилтууд тавигдсан. Энэ дотор 14 мега төсөл орсон. Энэ 14 мега төслийн 6 мега төсөл нь манай яамтай холбоотой хийгдэнэ. Тэгээд энэ төсөл хөтөлбөрүүд дотор зэс боловсруулах үйлдвэрийн төсөл 762 сая долларын ТЭЗҮ-тэй, хөрөнгө оруулалтыг бол гаднын хөрөнгө оруулалтаар хийнэ. Мөн тэр баяжмалаа өгөх гэж байгаа мөн патент эзэмшигч энэ тэр гээд олон вариантаар энэ асуудлууд яригдаж байгаа.

2 дугаарт нь энэ гангийн цогцолбор. Жилдээ 1 сая орчим тонн ган боловсруулах цогцолборын асуудал яригдаж байгаа. Энэ дээр бол 700 орчим сая долларын ТЭЗҮ яригдаж байгаа. Мөн алт боловсруулах үйлдвэр дээр бид.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайдад хугацааг нь нэмж сунгая.

Ц.Туваан: Алт боловсруулах үйлдвэр дээр өмнө нь бас нэг ТЭЗҮ боловсруулагдаад бас үнэ нь их өндөр байгаа. 81 сая доллар гээд. Одоо хамгийн сүүлд яригдаж байгаа хэмжээ бол 35-54 сая долларын хэмжээнд алт цэвэршүүлэх үйлдвэрийн асуудал яригдаж байгаа. Мөн үүнээс гадна манай 14 мега төсөл дотор энэ уран баяжуулах төсөл, газрын тосны төсөл. Мөн нүүрс, хими, кокс химийн төслүүд байгаа. Тэгээд эдгээр төслүүд дундаас бас ТЭЗҮ хийгдээгүй, хийгдэхээр төлөвлөгдөж байгаа төслүүд бас байгаа гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Түрүүн нөгөө аж үйлдвэрийн салбарыг сууриар нь хөгжихийг дэмжихийн тулд зам, тээвэр болон эрчим хүчний салбар дээр бид нар ийм бодлого боловсруулаад явж байгаа гээд Жавхлан сайд маань бас хариулж байна.

Би яг нөгөө Амарбаясгалан даргын захирамжаар нөгөө 54 ажлын хэсгийн Зөвшөөрлийн тухай ажлын хэсэгт нь орчихсон явж байгаа. Энэ зөвшөөрлийн ажлын хэсэг дээр 2, мэргэжлийн яамнуудтай уулзалт хийсэн. Эрчим хүчний яамныхантай уулзсан. Эрчим хүчний яамнаас би нэг л юм асуусан. Бид энэ либералчлал гэдэг юм уу, нэг бол эрчим хүчний салбартаа гадна дотнын хөрөнгө оруулалт дэмжиж энэ нь илүү өгөөжтэй байж байж энэ аж үйлдвэрийн салбарыг илүү дэмжих гээд байгаа юм. Тэгэхээр гаднаас 200 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт Монголд орж ирээд яг эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийгээд явахад танай яамны нөгөө зөвшөөрөл байдаг шүү дээ. Зөвшөөрлийг хэдий хугацаанд давж гарах вэ гэхэд мэргэжлийн боловсон хүчнүүд 2,5-3 жилийн дараа гэхэд болно гэж байгаа юм. Тэгэхээр гаднын хөрөнгө оруулагч нар 200 тэрбум төгрөгөө 200 тэрбум хөрөнгө оруулалтынхаа мөнгийг барьж.../минут дуусав/

С.Ганбаатар: Нэмж тодруулъя.

Г.Очирбат: Тэгэхээр бид чинь нөгөө загас толгойноосоо өтнө гэж дээгүүрээ ингээд гоё юм яриад байдаг. Яг амьдрал хөрсөн дээрээ буусан журам дүрмүүд чинь одоо бид нарын засгийн юу гэдэг юм бид нарын бариад бодлоготой нийцэж байгаа юм уу. Яг өнөөдөр эрчим хүчний салбар дээр бол авлига, хээл хахууль дэндчихсэн гээд танай мэргэжлийнхэн чинь хэлж байгаа шүү. Уулзаад сууж байхад. Сайд нь 2, 3 гарын үсэг зурж байж цаашаа ажил явдаг. Үгүй ээ, тэгээд сайд сайшааж байж явдаг ажил гэж ер нь байгаад байхаар чинь тэр нөгөө авлига, хээл хахуулийн чинь индекс яаж олигтой буух вэ дээ. Тэгэхээр энэ дээр бас тодорхой хариулт авчихмаар байна. Яг бид нарын барьж байгаа бодлого одоо мөрдөгдөж байгаа Эрчим хүчний тухай хууль, тэнд явж байгаа тусгай зөвшөөрлүүдтэй хэр нийцэж байгаа вэ гэдгийг асууя Жавхлан сайд аа.

С.Ганбаатар: Эрчим хүчний яамнаас хариулах юм уу. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд. Эрчим хүчний яам уу Очирбат гишүүн ээ. Жавхлан сайд хариулах юм байна. Танаас асууж байна. Очирбат гишүүн ээ, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгээс асууж байгаа юм уу. 5 дугаар микрофоныг нээж өгье.

Н.Тавинбэх: Гишүүний асуултад хариулъя. Би өөрийг чинь ямар мэдээллийн эх үүсвэрээс эрчим хүчний салбарт өгөгддөг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл 2,5-3 жил болж байгааг би сайн мэдэхгүй байна. Одоо байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журам дүрмийн хүрээнд бид нар 1 сарын дотор л бүх тусгай зөвшөөрлүүдээ өгч байгаа шүү дээ. 14-30 хоногийн дотор багтаж бүх зөвшөөрлүүд өгч байгаа. Хууль ч тийм байгаа.

Яах вэ, нэг биш хэд хэдэн төрийн захиргааны байгууллагуудаас зөвшөөрөл авч байгаа нь үнэн. Жишээлбэл Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв, яам гээд ингээд тус тусдаа өгч байгаа. Тэгэхдээ хугацаа бол хамгийн дээд тал нь 30 хонож л байгаа шүү дээ.

С.Ганбаатар: Төрийн нарийн бичгийн дарга хариулт өглөө. Дараагийн асуулт Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Алтаниширээгийн газрын тос боловсруулах үйлдвэртэй холбоотой асуулт байна. Энэ үйлдвэр 2022 онд ашиглалтад орох ёстой байсан. 2016 онд анхны гэрээгээр Энэтхэгийн Эксим банкнаас 1 тэрбум долларын зээл авсан. 2019 онд дахиад 236 сая доллар хэрэгтэй байна гээд дэд зээлийн гэрээ байгуулаад, дахиад авсан. Одоо гэтэл дахиад 431 сая доллар хэрэгтэй гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зээл чинь яаж төлөгдөх юм. Дэд зээлийн гэрээ байгуулах юм уу, үндсэн гэрээгээ дахиж давтан байгуулах юм уу. Яг ямар хуваарилалтаар төлөх юм. Юунд зарцуулах гэж байгаа юм. Яагаад ашиглалтад ороогүй юм. Тэгэхдээ ковид гэдэг рүү чихмээргүй байгаа юм. Тэгээд Энэтхэгээс авсан 1.236 тэрбум ам.долларын зээлийн гэрээнд чинь ийм юм байгаа байхгүй юу. Төслийн бүх ерөнхий гүйцэтгэгч нь Энэтхэгийн компани байна гэж байгаа юм. Бараа бүтээгдэхүүний 75 хувийг зөвхөн Энэтхэгээс хангана гэсэн ийм давуу эрхтэй. Тэгэхээр одоо энэ 431 сая долларын зээл чинь дахиад ийм давуу эрхийг олгох юм уу. 2027 онд ашиглалтад орно гэж яриад байгаа юм. Яг ашиглалтад орох уу, үгүй юу. Би энд Монгол Улсын Ерөнхий сайдад асуулга тавиад, холбогдох материалуудыг татаж аваад ажиллаж байтал дахиад 431 сая доллар ороод ирж байгаа байхгүй юу. Энэ газрын тосны компани чинь бас үйлдвэр чинь дахиад Хөгжлийн банкнаас 119 тэрбумын зээлтэй тийм үү. Хашаа

барина гэсэн. Энийг асуугаад тодруулга авна.

Энхбаяр сайдаас бас нэг юм асууя. Дорноговь аймгийн Хатанбулаг Хөвсгөл суманд ямааны годрон гэдэг өвчин гарсан. Одоогоор 14 мянган ямаа цаазлуулахаар болоод нүхийг нь нухаад бэлдчихсэн. Одоо бараг цаазалж байгаа болов уу даа. Тэгээд энд малчид вакцинд хамрагдаад л яваад байсан. Хий гэсэн мал эмнэлгийн тавьсан шаардлагуудыг хангаад л яваад байсан. Гэтэл 14 мянган ямааг цааши нь харуулах гэж байгаа байхгүй юу. Малчид зээл авчихсан байгаа. Хавар ноолуураа гарахаар төлбөрөө төлөх ёстой. Тэгээд таны саяын хэлдгээр 34 хувиар хөдөө аж ахуйн уналтад орчихсон. Сая их зуд турхан боллоо шүү дээ. Тэгэхээр энийг яаж зохицуулах юм. Одоо годрон гэдэг өвчин 1950 оноос хойш гараагүй гэх юм. Энэ үнэн үү. Тэгээд тэр вакцин чинь яагаад үйлчлэхгүй ийм өвчин гараад сая сонгуулийн үеэр энийг дарсаар байгаад гэнэтхэн ингээд олноор нь цаазлах боллоо гэсэн ийм гомдол ирээд байгаа юм. Тэгэхээр энд нөхөн олговор өгөх үү. Малчдад. Ээ асуултыг авъя.

С.Ганбаатар: Жавхлан сайд тэр газрын тосны асуудал дээр маш тодорхой асуулт асуулаа. Та хариулна. Дараад нь Ж.Энхбаяр сайд хариулна. Газрын тос дээр Туваан сайд.

Ц.Туваан: Маш тод тодорхой хариулъя. Энэтхэгийн Засгийн газраас авч байгаа хөнгөлөлттэй зээл 1 тэрбум, тэгээд сүүлд нь 230 тэрбум сая доллар нэмэгдээд 1,2 тэрбум доллар болсон. Энэ яг үйлдвэрийн гэрээ байгуулагдаад үйлдвэрийн ажлыг бүгдийг нь И Пи си 1, 2, 3, 4 багц болгоод ингээд хуваагаад ажиллаж эхэлсэн. Тэгээд 2019 оноос бол эхэлсэн. Коронаг бол ярихгүй байх аргагүй. Дунд нь яалт ч үгүй орсон. Энийг хэлчихье. 2019 оноос эхэлсэн. Тэгээд яг өнөөдрийн байдлаар энэ 1,2 тэрбум доллароос 251 сая долларыг л авч хэрэглэсэн гэсэн үг. Тэгэхээр энэ бол шууд

юу гэдэг юм Энэтхэгийн Засгийн газрын зээл учраас Энэтхэгийн талтай байгуулсан зээлийн дотор ерөнхий гүйцэтгэгчийг нь бол Энэтхэгийн компани байхаар заалт орсон учраас Энэтхэгийн компани гүйцэтгээд явж байгаа. Тэгээд тэр Энэтхэгийн Эксим банкнаас шууд ерөнхий гүйцэтгэгчийн данс руу ордог. Монголын компанийн данс руу бол нэг ч доллар ордоггүй ийм зохицуулалттай юм байна лээ. Ерөнхий гүйцэтгэгч компаниуд бол Монголын туслан гүйцэтгэгч компаниудыг аваад ажилладаг гэдгийг хэлье.

431 сая долларын нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа. Энэ нь И Пи Си 4 буюу яг энэ патенттай үйлдвэрийн хамгийн гол тэр нэрэх бусад тоног төхөөрөмжүүдийг авахад шаардагдаж байгаа мөнгө. Энэ бол зайлшгүй хэрэгцээтэй байгаа мөнгө. Тэгэхээр энэ хугацаанд дэлхийн эдийн засаг, дэлхийн зах зээл дээр юмны үнэ бол мэдээж бид нар бүгдээрээ мэдээж байгаа. Юмны үнэ нэмэгдсэн учраас энэ мөнгө бол нэмэгдээд гарахаар байгаа. Тэгэхээр энэ дээр бол мэдээж ерөнхий гүйцэтгэгч нь бол Энэтхэгийн компани байна. Туслан гүйцэтгэгчээр Монголын компаниуд орно. 2027 онд ашиглалтад орно гэж тооцоолж явж байгаа. Одоогийн байдлаар И Пи Си 4 дээр шаардлагатай байгаа 431 сая долларыг Энэтхэгийн Эксим банкнаас олгох шийдвэрийг гарах юм бол энэ шийдвэр гарч гэрээ байгуулагдаад, энэ гэрээ Улсын Их Хурлаар орж соёрхон батлагдсанаар хүчин төгөлдөр болно. 11 сард хүчин төгөлдөр болбол үүнээс 36 сар буюу 2027 оны 11 сард энэ үйлдвэрийг ашиглалтад оруулна гэж тооцоолоод явж байгаа.

Хөгжлийн банкнаас тодорхой 110 гаруй тэрбум төгрөгийн зээл авсан. Энэ Монголын талын тэр тухайн үйлдвэрийн байрны хашаа, зам, эрчим хүчтэй холбоотой асуудлууд дээр бол зээл аваад явж байгаа 10 хэдэн хувийн хүүтэй зээл аваад, хэрэглээд явсан гэдэг мэдээллийг өгье.

С.Ганбаатар: Энхбаяр сайд хариулах уу.

Ж.Энхбаяр: Энэ маань нэлээн эдийн засгийн хохирол өндөртэй тархалт их түргэнтэй, зөвхөн ямаанд тусдаг өвчин. 1960 оноос хойш үндсэндээ гараагүй байсан. Сая Монгол Улсын хилийн бүс нутаг Дорноговь аймгийн Хатанбулаг сумд хилийн районд үүссэн 35 айлын мал шинж тэмдэг илэрсэн. Яаралтай зохион байгуулалт хорио цээрийн дэглэм авч хэрэгжүүлж байна. Мэргэжлийн баг ажиллаж байна. Хүрээг тогтоогоод голомтыг устгах ажлыг цаг алдалгүй хурдан шуурхай зохион байгуулж ажил эхлэх гэж байна. Малчдын малын тэр зээлд хамрагдсан байдал малынх нь “А” дансны бүртгэл малчин өрхийн өмнөх хугацаанд шилжилт хөдөлгөөн хийсэн эсэх, тэр айлуудаар бусад туувар зөөврийн мал хунар орсон тэр айлуудаас адуу мал худалдагдсан гээд бүх л энэ чинь тархвар зүйн томоохон судалгаа шинжилгээний ажлууд ид хэрэгжээд үндсэндээ дуусаж байна. Тэгээд устгалд оруулах тоо хэмжээ тогтсон. Устгалыг яаралтай.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайдад микрофоныг нэмж өгье. Хамгийн гол нь нөхөн олговор хэд вэ. Хэзээ өгөх вэ гэдэг дээр их тодруулсан шүү дээ.

Ж.Энхбаяр: Нөхөн олговрыг олгодог учиртай. Энийг Улсын онцгой комисс дээр шийдвэрлэдэг ийм зохион байгуулалттай. Ер нь асуудлыг голомтыг бага дээр нь хумиад л дор дор нь шийдэж явахгүй бол цаг алдах ноцтой. Яагаад гэвэл их хохирол өндөртэй. 2-3 өдрийн дотор халуураад л тэгээд л ер нь үхээд байдаг. Тийм болохоор богино хугацаанд богино хүрээг нь хумих ажлыг хийж байна.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: 4 дүгээр багц дээр 431 сая доллар авна гэж байгаа шүү

дээ. Зээлнэ гэж байгаа шүү дээ. Тэгэхээр зээлдүүлэгч давуу эрх эдлэх үү. Ямар гэрээ хийгдэх юм. Тэгээд эргэн төлөлтөө жил болгоноор яаж явах юм. Хэдийгээс Монгол Улс ашиг авах юм. Олон улсын аудит орсон уу. Энэ яг Оюутолгой Дубайн гэрээний араас л яваад байх шиг байгаа байхгүй юу. Зээлдүүлэгч нь давуу эрх эдлэх үү. Нөхцөл нь ямар юм. Жилийн хэдээр төлөх юм. Монгол Улс хэзээнээс ашиг авах юм. Өмнөх зээлүүдтэйгээ хамтруулж төлнө шүү дээ.

С.Ганбаатар: Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Тийм. И Пи Си 4-ийн хүрээнд зайлиггүй шаардлагатай мөнгө нь энэ 431 сая доллар энэ долларыг нэмэгдүүлж өгөөч гэдэг хүсэлтийг сүүлийн 1 жил 6 сарын хугацаанд тавьж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайдаас хүртэл 7 удаа захидал илгээгээд, мөн яг энэ асуудал дээр бас Сангийн яам хүртэл ингээд оролцоод энийг шийдэж өгөөч ээ гэдэг хүсэлтүүдээ бид нар тавиад ингээд Засгийн газрын түвшинд явж байгаа. Давуу эрх гэдгийг нь бол ойлгосонгүй. Ямар нэгэн байдлаар гэрээний дагуу явагдана. Энэ мөнгө нь урдах мөнгөтэйгөө нийлээд 1,6 тэрбум доллар болоод явна. 5-7 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хэсэгчлэн төлөх нөхцөлтэйгөөр явагдаж байсан энэ хугацааг бол хойш нь сунгаад 2030 оноос эхлэн төлөхөөр жил болгон хувааж төлөхөөр ийм нөхцөлтэй зээл. Энэ Газрын тос боловсруулах үйлдвэрийн яг энэ гүйцэтгэлүүд дээр гаднын нэр хүндтэй компаниуд гэрээ.../минут дуусав/

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Одоо жишээ нь тэр зээлээ өгөхдөө давуу эрх эдлээд байгаа шүү дээ. Жишээ нь нөгөө ажил хийх компаниудыг сонгон шалгаруулна. Тэрнээс нийт бараа бүтээгдэхүүний 75 хувийг Энэтхэгээс хангана гэсэн ийм

заалтууд байгаа. Энэ нь хэвээрээ юм уу. Эсвэл дахиад тусдаа гэрээ байгуулаад байгаа юм уу. Өмнөх гэрээндээ ингээд үүнийхээ дор дэд зээлийн гэрээ хийгээд байгаа юм уу.

С.Ганбаатар: Туваан сайд тодруулъя.

Ц.Туваан: Энэ тусдаа биш. Нөгөө өмнөх 1,2 дээрээ нэмээд, нийлүүлээд 1,6 болох гэрээ, дээрээс нь манайхан бүгдээрээ мэдэж байгаа олон улсын олгож байгаа зээл, хөнгөлөлттэй зээл энэ асуудлууд дээр яг гэрээ байгуулагдаад санхүүжих гээд ирэхээрээ тэндээс тэр давхар гэрээн дотор нь тухайн улсын аж ахуйн нэгжүүдийг оруулах ийм заалтууд ороод яваад байгаа. Тэгэхээр энэ бол яг нэг тийм зүйл. Өөрөөр хэлбэл Энэтхэгийн талаас зээл авч байвал Энэтхэгийн компаниуд нь ингээд ерөнхий гүйцэтгэл хийгээд явж байгаа ийм асуудал байгаа.

Түрүүний асуудал дээр олон улсын компаниуд явж байгаа. ТЭЗҮ боловсрогдсон. Хяналтыг мөн олон улсын нэр хүндтэй шалгарсан компаниар аудитуудыг нь хийлгээд явж байгаа.

С.Ганбаатар: Зүгээр асууж байгаа юм нь Туваан сайд тодруулъя гэж байх шиг байна. Их тодорхой юм асууж байна шүү дээ. 2022 онд ар орох байсан. Одоо наадах чинь нэг л танил сонсогдоод байгаа байхгүй юу. Нөгөө Оюутолгойтой л адилхан. Бид ерөөсөө энэ аж үйлдвэрлэгч нарт хамгийн хэрэгтэй юм бол Монголдоо нефть боловсруулах. Энэ бид бүгдийн мөрөөдөл. Тэгэхээр 431 сая доллар зүгээр л талхны үнэ нэмэгдэж байгаа юм шиг л ороод ирлээ. Энэ дээр хөндлөнгийн шинжилгээ хийсэн компани нь байгаа гэж байна. Яг ямар компани юм. Аль улсын компани юм. Монголынх юм уу, Энэтхэгийнх юм уу, хаанахынх юм. Дээр нь нэмээд 431 урьд нь байхгүй байж байгаад яагаад гэнэт ороод ирэв. Тэгээд юмны үнэ хөөрөгдсөн л гэж байна. Үгүй ээ, энэ чинь талх биш шүү дээ. Яг

нефтийн тоног төхөөрөмжүүд дэлхий дээр 5-7 хувь л өссөн байгаа. Энэ бол тэгж их айхтар өсдөг зүйл биш. Ланд крузер хэдэн хувь өсөж байгаа билээ. Бид бүгд мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр тийм хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт байхгүйгээр барин тавин ярих юм бол би сайдад ярихаас илүү тэр яамны нөхдүүд нээрээ үнэн хариуцлагагүй юм. Энэ чинь монголчуудын төлөх мөнгө шүү дээ. Бидний хүүхдүүд дараа нь төлнө шүү дээ. Ямар бэлгийн морины шүдийг үзэхгүй гэдэг шиг Энэтхэгүүдийн мөнгө л гэж бодоод байх юм. Үгүй шүү дээ. Дараа нь бид төлнө шүү дээ. Тэгэхээр энэ дээр Мөнхбаясгалан гишүүний асуусан зүйл дээр тодруулж хэлээч. Ямар компани хөндлөнгөөс хар толгойгоороо хариуцаж, яалт ч үгүй 431-ээр инфляц хөөрөгдчихлөө гэдэг. Бид бүгдээрээ энийг дэмжихийг л хүсэж байгаа учраас асууж байгаа юм шүү.

Ц.Туваан: Яг үнэн. Ойлгож байгаа. Тэгээд дэлхийн зах зээл дээр энэ нефтийн газар тосны үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд өөрсдөө ингээд бэлэн байж байдаггүй. Энэ бүх гэрээ байгуулагдсаны үндсэн дээр компаниуд нь сонгон шалгараад, тэр сонгон шалгарсан компаниуд нь үйлдвэрлэж эхэлдэг, хугацаа шаарддаг ийм нарийвчлалтай тоног төхөөрөмжүүд. Тэгээд энэ дээр яалт ч үгүй л дэлхийн зах зээл дээр ковид нь байна уу, инфляц нь байна уу юмны үнэ бол өсчихсөн байгаа. Тэгээд энэ мөнгийг бол бид нар бас нэлээн нарийн тооцооллыг нь хийж үзсэн. Тэгээд Мөнхбаясгалан гишүүнд бас задаргаануудыг нь яг ийм нөхцөлөөр 431 нэмэгдэж байгаа гэдгийг хэлье. Тэгээд яг хяналт хийж байгаа компанийнх нь нэр алга байна. Энэтхэгийн Мега Инженеринг гэдэг компани энэ И Пи Си.../минут дуусав/

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Бас манай энэ газрын тос боловсруулах үйлдвэр чинь

ашиглалтын талбайгүй. Давст 32 талбай зарлана гэж байсан шүү дээ. Тэгээд би сая ингэж асуусан. Энэ авсан зээлүүдээ хэдэн жилийн хугацаанд, хэд хэдэн сая доллароор төлөх юм бэ. Тэр аудит яг хийсэн үү. Тэрийг яагаад одоо хүртэл тайлагнаагүй юм бэ гээд ингээд асуух юм их байдаг. Энэ хугацаанд ингээд баригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бид нар ажлын хэсэг гаргаад бүр шаардлагатай бол нийтийн сонсгол хиймээр байгаа юм. Тэгж байж энэ 431 сая долларыг нэмж зээл авах уу, үгүй юу гэдгээ шийдэж, Их Хуралд орохоос нь өмнө энэ асуудлыг нэлээн нухацтай яримаар байна. Ганцхан надад байгаа материалуудаас судалгаа хийгээд үзэхэд энд бол ихээхэн юм байгаа. Дубайн гэрээний л араас яг явж байгаа мэт санагдаад байгаа байхгүй юу.

С.Ганбаатар: Туваан сайд тодруулъя.

Ц.Туваан: Хугацаанд баригдалгүйгээр бас Мөнхбаясгалан гишүүнд эргэж би бас тодорхой мэдээлэл өгье. Энэ бол бид нарын Монголын ард түмэн, бидний үр хүүхдүүдийн төлөх мөнгө. Яг үнэн. 1,6 тэрбум энэ бол зээл. Дээрээс нь бид нар үндэсний аюулгүй байдалтай холбоотой нэг улсаас 95, 96 хувь хараат байдлаасаа гарах гэсэн нэг асуудал. Тэгэхээр энэ дээр бас бид нар 2 талтай ойлгох хэрэгтэй. Тэнд асуудал үүслээ гэхэд ноднин намрынх шиг асуудал үүсэхэд л бөөн асуудал байгаа. Тэгэхээр энэ үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын шингэн тунгалаг нефть бүтээгдэхүүнийхээ 55 хувийг бид нар хангана гэж үзэж байгаа. Ашгийн хувьд бол мэдээж энэ манай үйлдвэр. Яг өртөг бол мэдээж бас олон улстай өрсөлдөхүйц хэмжээний үнээр нефть бүтээгдэхүүн гаргана гэж ингэж тооцоолж байгаа. Тэгээд бас маш олон зүйлээс шалтгаалах учраас танд мэдээллийг энэ цаг дуусаж байна. Мэдээллийг дахиад өгье. Зээлийн хуваарийг Сангийн яам хэлчихье.

С.Ганбаатар: Жавхлан сайд тодруулъя.

Б.Жавхлан: Уул уурхайн яамны дэргэдэх зөвлөл дээр ТЭЗҮ, энэ дүн бүх юмнууд батлагдаад, зээлийн хэлэлцээр дээр Сангийн яамнаас оролцоно уу гээд манай дээр ирдэг юм. Тэрний дагуу Энэтхэгийн Эксим банкттай хэлэлцээд зээлийн хэлэлцээр нөхцөлүүд бас үргэлжлээд явж байгаа. Дутуу юмнууд бол байгаа. Одоогоор яг үзэглэгдчихсэн байгаа хэсэг дээрээ бол нийтдээ 20 жилийн хугацаатай юм. 7 жилийн үндсэн зээлээс чөлөөлдөг хугацаа нь эхний 7 жил. Ингээд жилийн 1,75 хувийн хүүтэй ийм 4 хэсэг гэрээ гэсэн үг. Өмнө нь ингээд нэг бүтэн гэрээ байсан юм. Нэг бүтэн гэрээ байгаад ингээд бусад ажлууд нь эхлээгүй байхад бие биеийгээ татаж унагаагаад эсвэл бие биеийнхээ гүйцэтгэл хүлээгээд дараагийн ажлууд нь эхлүүлж чадахгүй ийм зовлонтой гэрээ байсныг харин гэрээ дээр бол их сайжралт хийгдсэн. 4 хэсэг хуваагаад эхний ажлуудаа хүлээлгүйгээр 4 фронт дээр зэрэг явж байгаа ажлууд.../минут дуусав/

С.Ганбаатар: Жавхлан сайдад цаг нэмье.

Б.Жавхлан: 20 жилийн хугацаатай энэ зээлийн үндсэн нөхцөл маань 4 хэсэг дээрээ хугацааны хувьд наана цаана ороод өөр явна. Ерөнхий нөхцөл нь бол ийм байгаа.

С.Ганбаатар: Ойлголоо. Ингээд энэ дээр нарийвчилсан тоо баримт мэдээллүүдийг Мөнхбаясгалан гишүүнд өгөх юм байна. Мөнхбаясгалан гишүүн дараагийн Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээрээс асуулга асууж, энэ дээр нээлттэй мэдээлэл сонсгол хийх саналаа сая гаргалаа. Хамгийн гол нь дэлхий тэр чигээрээ цахилгаан эрчим хүч рүү явж байгаа үед бол нефть боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн асуудал дээр арай л өөр мэдээллүүд байгаа. Нарийвчилсан мэдээллүүдийг

бичгээр гаргаж өгнө гэж тогтлоо. Ингээд Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би энэ 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, 2025 оны төсөв дээр нэг асуудал тавиад байгаа. Юу гэхээр эрчим хүчний төслүүдийг гадаадын зээл тусламж руу шидээд байна. Энэ тохиолдолд бид нар яаж эрчим хүчний дутагдлаас гарах юм. Яаж энэ цахилгаан хангамж, дулаан хангамжийнхаа найдвартай ажлыг дээшлүүлэх юм бэ гээд. Тэгээд энэ тарааж өгсөн материалын хавсралт 14 дээр эрчим хүчний төслүүдийг гадаадын зээл тусламжаар санхүүжих жагсаалт харагдаж байна л даа. Тэгээд энэ жагсаалтаас харахад Багануур, Чойрын шугам, Мандалговь, Арвайхээрийн шугам, Эрдэнэбүрэн Мянгад, Улиастай, Сайншанд гээд ТЭЦ-3-ын өргөтгөл, Байдрагийн УЦС гээд бүгдээрээ гадаадын зээл тусламж гэсэн жагсаалтад байна. Тэгээд бүгдийнх нь мөнгөн дүн дээр болохоор ерөөсөө л 10 сая, 10 сая бүгд дээр нь. Тэгэхээр энэ яг юу гэсэн үг вэ. Өөрөөр хэлбэл энэ төслүүдийн төсөвт өртөг нь 10 сая юм уу, эсвэл бүр ингээд гадаадын зээл тусламж нь шийдэгдээгүй зүгээр ингээд нэг ийм символический байдлаар 10 сая гээд тавьсан юм уу. Энийг нэг тайлбарлаж өгөөч гэж үзэж байна.

2 дугаар асуудал нь болохоор солонгосын санхүүжилтээр хэрэгжиж байгаа аймгийн дулааны станцуудын төслүүд байгаа. Тэгэхээр энэ төслүүдийн явц нь ямар байгаа юм бэ. Эхнээсээ хэдэн онд яг эхэлсэн юм бэ. Хэдэн жил үргэлжилж байна. Энэ бол яг яалт ч үгүй л гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн нэг тод жишээ. Тэгэхээр яг хэдэн жил хэрэгжээд явж байна. Одоо ямар байдалд орчихсон, гацаанд орчихсон байгаа л гэсэн. Дээрээс нь Архангай аймаг дээр дулааны станц дээр бас нэг асуудал байгаад байгаа юм. Тэрийг бас нэг тайлбарлаж өгөөч ээ гэж үзэж байна.

3 дугаарт нь болохоор энэ төсөв дээр бүс нутгийн найдвартай цахилгаан хангамжийн 1 дүгээр үе шат гээд бүсүүд гээд яг ямар бүс нь тодорхойгүй. 59 тэрбум төгрөг тавигдсан байна л даа. Тэгэхээр 1 дүгээрт нь энэ яг аль аль бүсүүд орж байгаа вэ. 2 дугаарт нь энэ ажлын хүрээнд ямар ажлууд хийгдэх гэж байгаа вэ. 3 дугаарт нь энэ ажлуудын чинь яг зураг төсөл нь хийгдсэн юм уу. 4 дүгээрт нь болохоор Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Үенч сум хүртэлх 35 киловольтын ЦДАШ гээд 2019 онд эхэлсэн ажил байна. Өнөөдөр дуусаагүй. Анх эхлэхдээ 21 тэрбумаар эхэлж байсан бол өнөөдөр бараг 26,6 тэрбум болж төсөвт өртөг нь өсчихсөн явж байгаа юм байна. Тэгэхээр энэ төсөл маань бас ямар учиртай төсөл вэ гээд энэ 4 асуултад хариулж өгөөч.

С.Ганбаатар: Жавхлан сайд хариулъя. Техник, эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр зүгээр 10, 10 гээд тавьчихсан уу л гэж асууж байна. Бас тодорхой төслүүдээс нарийвчилж асуулаа.

Б.Жавхлан: Тэр зээлийн санхүүжилтийн бодлого хэсэгт нь Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэр тодорхой төслүүд дээр яам нь хариулсан нь зөв байх. Энхцэцэг гишүүн ээ, ийм байгаа. Бид төсвөө өргөн барьж байсан эхний танилцуулга дээрээ бас энэ талаар хоёулаа ярилцсан шүү дээ. Ер нь бид нар ингээд Монгол Улсын төсвийн санхүүжилт, бүтээн байгуулалтыг бид нар хийх хэд хэдэн эх үүсвэрийн боломжууд байдаг. Шууд төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншилэл гээд. Яах вэ орон нутгийг бид төсвийн бүрэлдэхүүн хэсэг хийхдээ бид тусад нь бас авч харах ёстой, тооцоолох ёстой юм байгаа юм. Энэ дотроос эрчим хүчний салбарын төслийн санхүүжилтүүд өөрөө их том дүн шаарддаг. Маши том дүн шаарддаг. Богино хугацаанд ашиглалтад оруулахыг ч мөн ингээд шаарддаг ийм онцлогтой төслүүд байдаг. Бид нар 100 мвт бүр

50ийг хэлье л дээ. 50 мвт ингээд л ярихад л энэ чинь 200 сая доллар бүр багадаа ингээж яригддаг. Гэтэл энэ маань өөрөө бид төсвөөсөө бас арай л төсөв дийлэхгүй, бидний хэрээс хэтэрсэн ийм зүйлүүд байдаг л даа. Богино хугацаанд. Бид нарын ойрын энэ 4 жилийн хугацаанд суурилагдсан эрчим хүчийг 2 дахин буюу 1700 мегабайтаар нэмүүлье гэх юм бол өнөөдрийн байгаа ханшаар зүгээр ойролцоогоор бодоход энэ чинь бараг дор хаяж 4 тэрбум доллар болох гэж байгаа байхгүй юу. Гэтэл өнөөдөр манай Монгол Улсын маань валютын нөөц өөрөө энэ хэмжээнд л байгаа. Тэгэхээр бид нар аль болох төсөв дээр бага дарамт аваад урт хугацаанд дарамтыг нь багасгаад болж өгвөл дамжуулан зээлээр явуулаад ингэх нь өөрөө манай төсвийн бодлогын хөрөнгө оруулалтын гол бодлого юм байгаа юм. Тэрнээс биш энийг чинь эрэмбэлээд чухал биш гэж үзээд энэ жилдээ төсвөөс биш юмаа гадаад тусламжаар гэж байгаа зүйл биш байхгүй юу. Харин ч эсрэгээрээ найдвартай эх үүсвэрийг нь гаргаж ирээд ялангуяа валютын тал дээр импорт дээрээ гарах урсгал дээрээ бид нар арай аль болох бага дарамт, сөрөг дарамт авах, тэгээд бид нар дунд хугацааны энэ гадаад өрийн стратегиа ч Их Хурлаар батлуулдаг. Энэ том бичиг баримт дээр ч бид нарт бүр маш тодорхой гэрийн даалгавар өгчихсөн байдаг. Ийм төслүүдийг гадаад зээл тусламжаар явуулах хэрэгтэй. Тэр нь тэгээд дамжуулан зээл байх буюу төлбөрийн тэнцэл дээрээ аль болох бага дарамттай байлгаач ээ гээд. Яах вэ, таны болгоомжлоод байгаа юм нь нөгөө бэлтгэл ажлыг хангах дээр ингээд 1, 2 жил болчихдог юм. Гадаад зээл, тусламж дээр хугацаа алдана л гэж ингээд болгоомжлоод байх шиг байгаа юм. Гэхдээ тэр хугацааны бэлтгэл ажлын тэр хугацаа чинь цаашидаа ингээд нөгөө яг тодорхой хугацаанд ашиглалтад ороод үр дүнгээ өгөхийг нь илүү их баталгаажуулж байгаа. Хэрвээ ийм том жишээ нь 200 сая долларын төслийг жишээ нь төсөв дээр авах юм бол ер нь

ойрын хугацаанд бүрэн ашиглалтад оруулж чадна гэдэг бол байгаа төсвийнхөө хэмжээнд бол бид нарын хэрээс хэтэрсэн зүйл байхгүй юу. Зүгээр ганцхан 50 мегабайтыг л татаж хийлгэдэг шүү дээ. Тийм учраас энэ дээр таныг бас ойлгоод энэ тал дээрээ яг төсвийн хөрөнгө оруулалт Монгол Улсын өөрийнх нь төсвийн багтаамж, төлбөрийн тэнцэл, гадаад валютын орох, гарах урсгал гээд л энийг бүх талаас нь хараасай гэж ингээж хүсэж байна.

Тэр нөгөө хэлэлцээр дээр явж байгаа төслүүдийг зээлийн ашиглалт дээр та дүн харсан шиг байна. Тэрийг Дэлгэржаргал дарга төслүүд дээр нь хэлээдэх. Тэр бусад яг тухайлан төслүүд дээр яам нь хариулах нь зөв байх.

С.Ганбаатар: 6 дугаар микрофон нээж өгье.

Ж.Дэлгэржаргал: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйл дээр гадаад зээл тусламжаар бид нар шинэ хэлэлцээр байгуулахад нэг шаардлага байдаг. Тэр нь бол төсөв талдаа ямар нэгэн эх үүсвэр тавигдсан байх ёстой гэж шаардлага. Тэгэхээр эдгээр төслүүдийн яг хэлэлцээрүүд нь эхэлчихсэн явж байгаа учраас 220 квт-ын 4 шугам явж байгаа. Байдрагийн УЦС гээд хэлэлцээрийн шатууд нь эхэлчихсэн. Нөгөө талдаа бид нар санхүүжүүлэх талдаа хуулийн шаардлагаа хангах нөхцөл нь төсөв талдаа ашиглалтаа тусгасан байх ёстой гээд энэ хуулийн шаардлагын хүрээнд тусгасан байгаа. Гадаад зээл тусламжийн ашиглалтын хувьд бол багц дүнгээр Сангийн сайдын багц дээр тавигддаг. Дээрээс нь энэ төслүүдийн гүйцэтгэлтэй нь уялдуулаад санхүүжүүлдэг учраас хэрвээ хэлэлцээр нь байгуулагдахгүй бол гүйцэтгэл гарч байгаа төсөл дээрээ санхүүжилтээ олгоод, хэлэлцээр нь байгуулагдаад,

гүйцэтгэл гарвал санхүүжилтийг нь нэмэгдүүлээд явах ийм боломжтой байдаг.

С.Ганбаатар: Үндсэндээ 10, 10 сая төгрөг чинь ямар ч ТЭЗҮ-гүй, тооцоогүйгээр зүгээр л шууд ижилхэн тавьчихсан гэж ойлгож болох уу. Уг нь тэгж асуусан биз дээ. 6 дугаар микрофонд өгье дөө. 4 дүгээр микрофон.

Б.Жавхлан: Энэ ийм байхгүй юу Ганбаатар дарга аа. ТЭЗҮ, зураг төсөв нь бүх юм нь хийгдээд, зээлийн хэлэлцээр явах шатандаа цаанаас тавьж байгаа шаардлага нь болохоор Монгол Улсын тухайн жилийн төсөв дотор тодорхой хэмжээгээр зээлийн ашиглалт чинь тусгагдсан байх баталгаа бид нараас нэхдэг. Баталгаа нэхдэг. Тэрний дагуу тавьж байгаа зүйл. Тэрнээс биш зураг төсөв, ТЭЗҮ-гүй юмнууд хэлэлцээрт орно гэж бол байхгүй л дээ.

С.Ганбаатар: Тэр холбогдох төслүүдийг холбогдох яамдууд нь тус тусад нь хариулах уу. Тавинбэх Төрийн нарийн бичгийн дарга.

Н.Тавинбэх: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Хөшөөт, Үенчийн шугамын талаар тодруулж байна. Хөшөөтөөс Үенч хүртэл 220км урттай 35 киловольтын ЦДАШ холбогдох дэд станцын хамт барих ёстой. Ховдын 3 сум, Булган, Үенч, Алтай, БНХАУ-аас импортоор авч байгаа. Энийг дотоодын эрчим хүчээр хангах ийм зорилготой шугам байгаа. 2019 онд гэрээ хийсэн. Санхүүжилттэй холбоотойгоор маргаан гарснаас болж шүүх дээр нэлээн удсан. Ингээд ажил 2021 оноос хойш эхэлсэн. Гэрээ шинэчлэн байгуулж. Ковидын үнийн өсөлт хийх журамд Их Хурлаас баталсан журамд багтаж байгаа учраас үнийн өсөлт хийсэн. Мөн та мэдэж байгаа байх 220 километр урттай 35-ын шугам бол ачаалал дамжуулах чадвар муу учраас энэ дээр нэмэлт арга хэмжээ авч бас төсөвт өртөг нэмэгдсэн байгаа. Өөрөөр хэлбэл 5 орчим тэрбум

төгрөгөөр төсөвт өртөг үнийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Тавинбэх дарга тодруулах уу. Нэмж 1 минут өгье.

Н.Тавинбэх: Нэмэгдсэн байгаа. Одоо энэ ажил дууссан. Улсын комисс ажиллаж байна. Ингээд дотоодоос нэр дурдсан 3 сум эрчим хүчээр хангагдах боломжтой болно. Бүс нутгийн цахилгаан хангамж нэрийн доор 59 тэрбум төгрөг тавигдсан байгаа. Энэ ажлын хүрээнд сумдын нам дунд хүчлийн хуваарилах сүлжээг шинэчлэх, сумд хоорондын нам хүчлийн хуваарилах сүлжээг шинэчлэх ажил хийгдэнэ. Ер нь улсын хэмжээнд бид сумд, сумд хоорондын нам хүчлийн хуваарилах сүлжээг шинэчлэх ажил дээр мониторинг шинжилгээ хийсэн. 200 орчим тэрбум төгрөгийн ажил хийх шаардлагатай байна гэдэг ийм дүн гарсан. Энэ ашиглалтын шаардлага хангахгүй хүчдэлтэйгээс болоод хөдөө, орон нутагт ялангуяа сумдад бол цахилгаан хангамжийн чанар хүртээмж маш муу байгаа. Тийм учраас Улаанбаатар хотын хувьд бид нэлээн өнгөрсөн 4 жилд нэлээн арга хэмжээ авсан. Тодорхой үр дүн гарсан. Одоо сумд руу орж байна гэж ойлгож болно. 200 тэрбумаас эхний шатын 59 тэрбум төгрөгийг энэ жилийн төсөвт тусгасан.../минут дуусав/

С.Ганбаатар: Тавинбэх даргад дахиад хугацаа сунгая.

Н.Тавинбэх: Санал хүргүүлсэн байгаа. Энэ 200 тэрбумд Монгол Улсын хэмжээнд сумдын нам дунд хүчлийн хуваарилах сүлжээг шинэчлэх бүх ажлууд зураг төсөвтэй. Гэхдээ бид нар эхний шатны төсөвтөө багтаагаад эрэмбэлээд сайдын тушаалаар сонгоод ажлаа хийгээд явна.

10 аймгийн төслийн хувьд тодорхой мэдээлэл өгье. Олон гишүүд сонирхож байгаа байх. Солонгосын Эксим банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нэр

бүхий 10 аймгийн төвд дулааны станц барихаар төсөл 2015 онд эхэлсэн. ТЭЗҮ хийгдсэн. Зээлийнхээ нөхцөлөөр Солонгосын компани энэ барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ёстой. Нэлээн удсан. Тэгээд 2021 онд бид нар тендер зарлаж, 2022 онд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. 26 сарын хугацаанд энэ ажлыг хийх ёстой байсан. Харамсалтай нь өнөөдөр ажил дуусаагүй байна. Гэрээний хугацаа дууссан. Өнөөдрийн байдлаар нийт ажлын гүйцэтгэл дунджаар 44 хувьтай байна..../минут дуусав/

С.Ганбаатар: Хугацааг сунгая. Тавинбэх даргад.

Н.Тавинбэх: Ажлын явц муу. Гүйцэтгэгчийн нөхцөл байдалтай холбогдуулаад бид нар өчигдөр төслийн удирдах хороо хуралдаж гэрээг цуцлахаар шийдвэр гаргасан байгаа. Гүйцэтгэгч ажил муу явж байгаа шалтгаанаа үнийн өсөлттэй холбоотой тайлбарладаг. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хувьд И Пи Си нөхцөлтэй. И Пи Си үнийн тохируулгагүй ийм гэрээ байгаа учраас бид бол гүйцэтгэгчээс тавьж байгаа үнийн өсөлтийг шийдэх боломжгүй. Тийм учраас гэрээ цуцалж, бид нар дахин үлдсэн ажил дээр тендер шалгаруулахаар бэлтгэл ажил хангахаар явж байна.

Архангайн хувьд бол одоо байгаа дулаанаар хангах тусгай зөвшөөрөл шүүхийн маргаан гарсантай холбоотой үндсэндээ 4 жил шүүхээр энэ маргаад явж байна. Сая хамгийн сүүлд Арбитрын шүүхээр эцсийн шийдвэр гарсан. Дахин энэ асуудлаар шүүхэд хандах боломжгүй болсон. Бид Архангай дээр тендер зарласан. Харамсалтай нь бас үнийн өсөлттэй холбоотойгоор гүйцэтгэгч орж ирэхгүй байж байна. Бид нар төсөв дээр нь тодотгол хийгээд.../минут дуусав/

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн асуулт асууя. Тавинбэх дарга дахиад нэг минут сунгаад хариулчихъя. Дутуу хариулчих шиг боллоо.

Н.Тавинбэх: Эрчим хүчний салбарын хэмжээнд гадаадын зээл тусламжаар одоо хэрэгжиж байгаа 8 төсөл байна. Хэрэгжих гэж бэлтгэл ажил хангаж байгаа 2, хүлээлтийн шатад байгаа 4 ийм төсөл байна. Ер нь нийт дүн нь 1,4 тэрбум ам.доллар-ын төсөвт өртөгтэй. Хэрэгжиж эхэлсэн төслүүдийн хувьд бол Сангийн сайд дээр санхүүжилтийн эх үүсвэр нь багцаараа тавигддаг. Гүйцэтгэлээрээ санхүүжигдээд явдаг ийм л учиртай.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Хөдөө аж ахуйн сайдаас асууя. Малын түүхий эд боловсруулах дээр ямар ямар яг бодитой хөрөнгө оруулалтууд төслүүд явж байгаа вэ. Энэ дундаа Дарханы арьс ширний цогцолбор дээр цэвэрлэх байгууламж нь улсын төсөв дээр тавигдаад, 2027 он хүртэл гэгчихсэн байна. Тэгэхээр цэвэрлэх байгууламж нь 2027 онд дуусаж байгаа юм бол үйлдвэр нь хэзээ бараг 2030 он руу явах юм биш үү. Тэгэхээр малчид бол Монгол Улс энэ нийт малынхаа арьс ширийг 2030 он хүртэл ер нь боловсруулахгүй юм уу. Энэ дээр маш тодорхой хариулт авъя.

Мөн хувийн хэвслүүд энэ малын гаралтай түүхий эдийг боловсруулъя гээд төрөөс дэмжлэг, бодлогын бас зээл, тусламжийн ийм дэмжлэгүүд хүсэж байдаг. Энэ дээр энэ жилийн төсөв дээр яг бодитой тавьчихсан юм юу байгаа вэ. Жижиг, дунд үйлдвэрлэлийн 25 тэрбум өөрөөрөө эргэж байгаа гэсэн. Энэ нэмэгдэх боломжтой юу. 25 тэрбум гэдэг үндэсний хэмжээнд бол маш олон үйлдвэрлэгч дунд бол энэ их бага мөнгө. Урьд нь бол төсөл хэрэгжихэд нэг эрэг боолт дутахад л тэр үйлдвэр ажиллах боломжгүй болдог. Тэгэхээр ийм ам

хааж байгаа юм шиг өгсөн төсвийн дүнг нь дандаа бууруулж жижиг жижиг дүнгээр олон хүнд таалагдах гэж ингэж оролддог. Энэ нь бодлого зөв үү буруу юу. Энхийгээ ер нь цаашид засах уу.

Мөн сумд олон үйлдвэрүүд улсын төсөв дээр тавьсан байна. Энэ бол нэг талаасаа сайн хэрэг гэж байгаа. Гэхдээ менежмент нь яах юм бэ. Тэнд бас нэг дарга оччихсон намчирхаад суугаад байх вий дээ. Энэ үйлдвэрийн ашиг яах юм. Эзэн нь хэн юм гэдэг. Энэ улсын төсвийн хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн менежментийн асуудал.

Энэ өвөл бас өмнөх өвөл шиг хатуу болох шинж тэмдэгтэй байна гэсэн олон хүмүүс, мэргэжилтнүүд цахим сүлжээгээр ярьж байна. Түрүү жилийн зуд шиг иймэрхүү асуудал болбол Засгийн газар хэр бэлтгэлтэй байгаа вэ. Айл болгонд 1 боодол өвс, 1 шуудай хивэг гэдэг шиг түрүү жилийнх шиг бас ийм юм явах вий дээ. Тэгээд энэ 5 асуултад хариулт авъя.

С.Ганбаатар: 5 асуулт асуулаа. Мааш тодорхой, товч хариулаарай. Эхний асуулт нь Болдын Жавхлан сайд хариулна. Дараа нь Энхбаяр сайд хариулна.

Б.Жавхлан: Мөнхтулга гишүүний асуултад хариулъя. 2022 онд орсон Төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтүүд, мөн тэр жил орсон хэмнэлтийн тухай хуулийн өөрчлөлтүүдээр таны ярьж байгаа саяын тэр эрсдэл бол эрс багассан шүү. Тэрэнд ямар заалт орсон бэ гэхээр аливаа шинэ төсөл хөтөлбөрийг төсвөөс санхүүжүүлэхээр бол цаад талын хугацаа 3 жил байх ёстой гэдэг ийм заалтыг Засгийн газраас, Сангийн яамнаас санал оруулаад батлуулж авсан. Ингэснээр тэр тэр хугацаанаас хойш орж ирж байгаа аливаа төсөл хөтөлбөрүүд бүгд 3 жилийн дотор ашиглалтад орохоор ингэж заасан байгаа гэсэн үг. Сая таны саяын ярьж

байгаа тэр дэд бүтцийн асуудал ч гэсэндээ Энхбаяр сайд нэмж хариулах байх. 2027 гэдэг маань 2025, 2026, 2027 гээд 3 жил гэсэн үг. Тийм учраас тэр эрсдэл бол эрс багасаж байгаа гэсэн үг. Цаашидаа ч гэсэндээ бид нар Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль тусдаа ийм хуультай больё гэж ингэж зорьж байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ч ийм зөвлөмж ирсний дагуу ойрын хугацаанд энэ хуулийн драфтыг бичих ажил эхлээд явж байгаа шүү.

Ер нь цаашидаа улсын төсвөөс аль болох хувийн хэвшилтэй өрсөлдөх зах зээл булаацалдах хувийн хэвшил өөрсдөө хийгээд явж байгаа үр өгөөжтэй ийм салбарууд руу төсөв хөрөнгө оруулалт хийж, аливаа шатын шүү сумын ч бай орон нутаг, аймгийн ч бай улсын ч бай ийм үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг байгуулахыг бол зогсоох хэрэгтэй. Энхийг бол хязгаарлах хэрэгтэй. Хэд хэдэн аймаг сумдууд дээр бол Улсын Их Хурлын гишүүд тойргоос гарч ирсэн саналын дагуу томоохон үйлдвэрүүд байхгүй дээ. Тэр нэг жижиг тийм цех, бяслагийн үйлдвэрийн хэмжээний жижиг хөдөө аж ахуйн чиглэлийн боловсруулах чиглэлийн үйлдвэрүүд 2-3 аймаг дээр байгаа. Энэ тоног төхөөрөмж, цехүүд нь бэлэн болохоор тухайн орон нутагтаа аймаг сумын өмчид бүртгэгдээд, цаашаагаа тэр нь энэ үйл ажиллагааг нь аваад явах ийм зохицуулалттай байгаа. Жижиг, дунд үйлдвэрийг сайд хариулах байх.

С.Ганбаатар: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Жижиг, дунд үйлдвэрийн эх үүсвэр нэмэгдэх боломж байхгүй. Байгаа энэ эх үүсвэрээ үр дүнтэй ашиглах хэмжээнд явна. Энэ түвшиндээ 2025 онд төсөвт суусан байгаа. Үндсэндээ нэмэлт хөрөнгө 0 гэж.

Түүхий эдийн боловсруулалт дээр юу хийж байна вэ гэж. Энэ маань Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилсан “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд энэ бодлого орж ирж байгаа. Ер нь хөдөө

аж ахуйн гаралтай гол түүхий эд болсон ноос, ноолуур, арьс шир, энийгээ бэлтгэх, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэхийн тулд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжүүлэх, гааль, татварын бусад таатай орчныг бүрдүүлэх энэ хөтөлбөр 2028 он хүртэл “Цагаан алт” гэж хэрэгжинэ. Нийтдээ 1,5 их наяд төгрөгийн зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энд үзүүлнэ. 1,5 их наядыг энэ арьс ширний боловсруулалтад оруулахын тулд улсын төсөв жил жилдээ нийт 304,3 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайдад нэмэлт хугацаа өгье.

Ж.Энхбаяр: Энэ жилд ачаалал нь 70 гаруй тэрбум төгрөг байгаа. Улсын төсөв. Гол зорилго бол бага мөнгөөр их эдийн засгийн эргэлтийг, их өгөөжийг бий болгох. Гол нь арилжааны банк, хувийн хэвшил гол үүргийг гүйцэтгэж байгаа юм. Тэгээд “Цагаан алт”-ыг бол бүгдээрээ 1,5 их наядын төсөл 2028 он хүртэл хэрэгжиж, улсын төсөв 4 жилийн хугацаанд 304-ийг ээлж дараалан суулгана гээд ойлгоход энэ хүрээнд бол боловсруулалтын түвшинд нэлээн бодитой ахиц гарч, эцсийн бүтээгдэхүүн экспортын чадавх нэлээн нэмэгдэнэ гэсэн тооцоотой явж байгаа хөтөлбөр.

Дарханы арьс ширний болон хөнгөн үйлдвэрүүдийг төвлөрүүлэх газрын судалгаа хийгдсэн. Үндсэндээ Монгол Улсын хэмжээнд Дархан-Уул аймаг буюу Дархан хотод энэ аж үйлдвэрийг хөгжүүлэх тодорхой хэмжээний дэд бүтцийн эх үүсвэр уур, ус, цэвэрлэх байгууламж, ариутгах татах төхөөрөмж нөгөө боломж энэ бүс нутагт л байгаа юм. Өөр бусад 20 аймагт байхгүй. Улаанбаатар хотод техникийн нөхцөл байхгүй. Боломж байхгүй, газар байхгүй. Тийм болохоор Дархан.../минут дуусав/

С.Ганбаатар: Нэмэлт авах уу. Энхбаяр сайдад нэмэлт тодруулах хугацаа өгье.

Ж.Энхбаяр: Тийм учраас Дархан-Уул аймагт байгаа энэ дэд бүтэц дээр тооцоолоод бид нар нийт Дархан арьс ширний цогцолбор буюу энэ 119,5 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, эдийн засгийн тооцоотой ийм ажил яваа. Зэрэгцээд явна. Хэрвээ 2025 оноос ажил эхэлнэ. Төсөв дээр тодорхой хэмжээний эх үүсвэр батлагдсан байгаа. Тэгээд бид энэ эх үүсвэрээр энэ ажлаа эхлэхийн зэрэгцээ энэ бодлого батлагдана гэсэн үг. Тэгэнгүүт хувийн хэвшилээ уриа, зэрэгцээд үйлдвэрүүдээ бариад явна л гэсэн үг. Зэрэг л явъя гэж. Төр зөвхөн дэд бүтцийн буюу хамгийн их зардлыг нь шийдэж өгнө. Цэвэрлэх байгууламж дээр нь хөрөнгийг нь оруулж өгнө. Газрын асуудал нь шийдсэн. Тэгээд дотроо юу барих нь бол энэ бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалтаар шийдэгдэнэ. Ийм маягаар үйлдвэржилтийн бодлогод төр оролцоно. Тэрнээс төр өөрөө арьс элдээд, ноос угаах буюу үйл ажиллагаанд орохгүй буюу төвлөрүүлэх кластераар хөгжих тэр дэд бүтцийг нь л хангах нь их чухал гэж үндсэндээ шийдсэн. Тэгээд энэ хүрээнд л ажил явагдана.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн тодруулъя.

П.Мөнхтулга: Цэвэрлэх байгууламж нь л ингээд 3 жил дамжаад 2027 онд дуусах юм байна. Өөр бусад таны яриад байгаа тэр бусад дэд бүтцүүд ариутгах татуурга холбох, тэр нөгөө уур, цахилгаан энэ зөвхөн цэвэрлэх байгууламж гэгчихсэн байна шүү дээ. Үйлдвэрлэлийн цэвэрлэх байгууламж гээд энэ 19.1.2 дээр байна л даа. Тэгээд би өөр бусдыг нь хайгаад олохгүй байна л даа. Тэгэхээр бусад дэд бүтцүүд нь хэзээ суугдаад хэзээ дуусах юм бэ. Тэгээд эд нар чинь 1 нь л дутвал үйлдвэр ажиллахгүй шүү дээ. Та надад яг тодорхой энэ бүрэн хөтөлбөрөөрөө

хувийн хэвшилтэйгээ нийлээд төрийн дэд бүтцүүд яг хэзээ дуусах юм б. Тэгэхгүй бол хэдий хүртэл манай малчид арьс ширээ жалганд хаях юм бэ гэдэг л тоо хэрэгтэй байна л даа. Тэр хүртэл бид нар арьс ширээ хэрэггүй, жалганд хаяа гэдэг тийм төсөөлөл байх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ чинь ингээд хэзээ нь мэдэгдэхгүй яваад байгаа байхгүй юу.

С.Ганбаатар: Энхбаяр сайд тодруулж хариулна.

Ж.Энхбаяр: Энэ жишээлбэл 25 га талбайд хэрэгжих Дархан арьс ширний цогцолбор байгаа юм. 2км цэвэр усны шугам 100-гаар, 3,2 км урттай дулааны шугам 300-ийн, 3,2 км урттай уурын шугам 300-ийн, 5,5км 14 метр өргөнтэй авто зам, 3,1 км урттай бохирын шугам 600-гийн хоолойгоор, 110 кВтын цахилгаан дамжуулах шугам, 7.1 километр холбооны магистрал шугам гэсэн ийм шугам, зураг төсөл гарсан. Төр бол цэвэрлэх байгууламж болон саяын нэр дурдсан дэд бүтцийг нь л татна. Ингэснээр хөрөнгө оруулалт хийх аж ахуйн нэгжүүд энд ажиллах орчныг нь л бүрдүүлж байна. Бүрдүүлнэ л гэсэн үг. Үүнээс цааш төрийн оролцоо байх нь зохисгүй. Төр бодлогыг нь гаргалаа, газрыг нь гаргалаа, дэд бүтцийг нь татлаа, Төвлөрлөө. Өнгөрсөн нэлээн хугацаанд энэ арьс шир түүхий эд боловсруулах гээд нэлээн хөдөлсөн боловч маш их хөрөнгө тарамдсан. Жижиг түвшинд цехийн хэмжээг нь шийдэх гэж оролдсон. Энэ чинь цаанаа бас нарийн аж үйлдвэрлэлийн зориулалтын уур, дээрээс нь.../минут дуусав/

С.Ганбаатар: Чухал зүйл ярьж байна. Энхбаяр сайд дахиад тодруул даа.

Ж.Энхбаяр: Тэгэхээр энэ төвлөрсөн бодлогоор Дарханд хүнсний үйлдвэрийн болон хөнгөн үйлдвэр, хөнгөн үйлдвэр дотроо арьс шир, ноос ноолуур, энэ даавуу даалин гээд 2 паркаар нь төвлөрүүлж. Бидэнд байгаа дэд бүтцийн бололцоо нь энэ байна. Хөвдод хөдөө аж

ахуйн арьс ширний бас хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах парк баригдаад, ажил нь нэлээн идэвх сайтай 70 гаруй хувийн гүйцэтгэлтэй явж байна. Тэнд мөн адил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар яг үйлдвэрлэлийн цэвэрлэх байгууламж хийгдэж байгаа. Энэ бол ахуйн цэвэрлэх байгууламжаас өөр, үйлдвэрийн цэвэр байгууламж буюу тэр химийн бодисыг шүүдэг, барьдаг, тунгаадаг, ийм нарийн деталь. Нэлээн өндөр түвшиний хөрөнгө оруулалт ордог болохоор хувийн хэвшлийн энэ үйлдвэрүүд дийлэхгүй байгаа юм. Тэгэхээр төр энэ гол ачааг нь үүрээд өгөхөөр энэ нэлээн төвлөрсөн ийм бодлого явна.

Улаанбаатар хотод Эмээлтийн аж үйлдвэрийн парк гээд хотын төсөв дээр суурилсан хотод нэг аж үйлдвэрийн парк, Дарханы хөдөө аж ахуйн парк, ингээд Ховдын аж үйлдвэрийн парк гэсэн гол ажлууд. Тэгээд бага хэмжээнд Баянхонгор, Өвөрхангай, Хархоринд бага, бага хэмжээний жижиг цехүүд. Зөвхөн ноос угаах.../минут дуусав/

С.Ганбаатар: Пунсалмаа гишүүн асуулт асууя. 2 асуултад хариулаагүй гэж байна шүү. Тэгвэл тэрийгээ тодруулаарай. Ямар 2 асуулт байсан бэ. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ өвөл эрт болж байгаа. Энэ жил бүх тариа, ургамлын болц 2 7 хоногийн өмнө түрүүлж болж байгаа ийм сонин зүйл анзаарагдаж байна. Өвлийн хур тунадас огцом дулаарах, огцом хүйтрэх буюу бэлчээр хэвтэр хүндрэх ийм байдал өнгөрсөн жилийн байдал нэлээн давтагдана гэсэн Цаг уурын газраас, Онцгой байдлаас анхааруулаад байгаа. Тэгэхээр Хөдөө аж ахуйн яамны тухайд бол бид тэжээлийн таримлаа эрс нэмэгдүүлсэн. Бараг 100-аад мянган га-д тэжээл тарьж, 200 гаруй мянган тонн тэжээлийг бэлдсэн. Тэгээд л бид нарын нөгөө байгаа бололцоо чадавх маань энэ. Түүрүн хэлдэг яаралтай дор хаяад 200 мянган га талбайг эргэлтэд оруулж, аймаг бүс

болгон тэжээлийн аж ахуйнуудыг, малчдыг, хоршоодыг тэжээл тарих бололцоог нь бид нар зохион байгуулалтыг хийж өгөхгүй бол одоо байгаагаар болохгүй нь. Байгаа хадлангаараа бэлчээрээр явна гэхээр үндсэндээ хадлангийн гарц унасан нөгөө малын тоотой холбоотойгоор. Тэгээд бэлчээрээсээ малчин таргаа авч чадахгүй болохоор эрсдэл нь өндөр болоод байна. Иймд бид нар бэлчээрийн биш тэжээлийн баазуудыг.../минут дуусав/

С.Ганбаатар: Гүйцээсэн биз. Мөнхтулга гишүүн тодруулъя гэж байгаа юм уу. Тодруулчихъя. Тэгээд дараа нь Энхбаяр сайд гүйцээж хариулаарай.

П.Мөнхтулга: Маш энгийн тодорхой л асуулт асуугаад байгаа юм. Түрүү жил шиг хүндэрвэл бид нар айл болгонд 1 боодол өвс, 1 хивэг өгдөг шиг тийм түрүү жилийн нөөцөөс илүү байгаа юм уу, дутуу байгаа юм уу.

2-т нь тэр нөгөө Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан дээр нэмэлт байхгүй гээд. Тэгсэн мөртөө энэ төсвийн төлөвлөлт дотор чинь Жижиг, дунд үйлдвэрлэлийн ажлын байрыг суурь түвшин нь 1 мянга байна. 2025 оны зорилтот түвшин 2 мянга гэхчхэн байгаа байхгүй юу. Тэгээд ингээд 2 мянгаар ажлын байрыг нэмж байгаа мөртөө ямар эх үүсвэрээр нэмээд байгаа юм гэдэг нь тодорхойгүй байна. Тэгээд эх үүсвэр тавиагүй мөртөө ажлын байр нь ингээд шууд 2 мянгаар өсчих юм уу. Тэгээд маш энгийн асуулт. Түрүү жилийнхээс манай Засгийн газрын нөөц их байгаа юу, бага байгаа юу.

С.Ганбаатар: Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Нөөц бол түрүү жилийнхээ түвшинд л байгаа. Хамгийн гол нь Хөдөө аж ахуйн яам өнгөрсөн байдалд дүгнэлт хийгээд, махны экспортыг онцгой анхаарч идэвхжүүлж байгаа. Махны экспортыг идэвхэжсэнээр

манай мах Төв Ази, Алс Дорнод, энэ Арабын хойг, ингээд сая Вьетнамд анхны контейнер очлоо. Евро Ази эдийн засаг холбоотой гэрээ хийж байна. Экспортоо нэмж байж малчдыг малаа борлуулах идэвхжилийг л төрүүлэх, нөгөө талаас малчид маань нэлээн ойлголт авсан. Нэлээн том сургамж авсан. Нэлээн их хэмжээний малыг нөөцөд бэлдэх ийм ажил л хийгдэнэ. Тэгэхгүй бол улсаас очих байгаа нөөцийг хуваахад 1 шуудай хивэг, 1 боодол өвсөөсөө илүү гарахгүй гэдэг нь тодорхой. Тэгэхээр аль болох эргэлтэд оруулахын тулд экспортыг идэвхжүүлж байгаа юм. Зах зээл нь нээж байгаа юм. Ингээд бид нар жилдээ 15 сая хүргэж мал боловсруулаад, экспортод гаргадаг болж чадвал.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайд аа, тэр айл болгонд 1 ганц боодол өвс өгөх үү, нэмэгдэх боломж байгаа юу. Хэдэн тонн нэмэгдсэн бэ гэдэг л тийм л юм асуулаа. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Тэгэхээр тэжээл бол үйлдвэрлэл ирэх жилээсээ эрс нэмэгдсэн. 200 гаруй мянган тонн тэжээл бэлтгэгдсэн. Энэ дээр нэмэхэд нь иргэдийн өөрсдийн хийсэн аж ахуйн хадлангууд орж байгаа. Энэ Монгол Улсад сая бүртгэгдсэн нийт өнгөрсөн хорогдлоо аваад 14 сая гаруй төл аваад 77, 78 сая мал өвөлжинө. Энд хүрэлцэхгүй. Иймд аль болох энэ эргэлтэд оруулах, малаа бэлтгэх, төхөөрөх, тэр экспортыг нээж өгч байгаа зорилго маань энэ. Махыг зах зээлд үнэтэй зах зээлд бид нар аль болох л олноор гаргах хэрэгтэй байна. Бэлчээрийн даацаа бодсон ч тэр, хадлан тэжээлийн нөөцөө бодсон ч тэр аль болох л эргэлтэд оруулдаг мал аж ахуйн эрхлэх арга ухаандаа бид нар өөрчлөлт эрс хийх хэрэгтэй.

С.Ганбаатар: Ойлголоо Пунсалмаа гишүүн асуулт. Тэрийг дутуу хариулсан байна шүү. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуйн яамны хэрэгжүүлэх “Цагаан алт” хөтөлбөр, Хүнсний хувьсгал хөдөлгөөн, Шинэ малчин, Чинээлэг хоршоо, хөдөлгөөн, Атрын 4 дүгээр аян энэ болгон маань өөрөө ажлын байрыг нэмэгдүүлнэ. Энэ болгон Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжинэ. Жижиг, дунд гэж ердөө ялгаа байхгүй. Хөдөө аж ахуйн салбар хамгийн их баялгийн хуваарилалтыг хийдэг. 600 мянган хүн ажиллаж байгаа салбар. Дотоодын нийт бүтээгдэхүүний 30 гаруй хувь үйлдвэрлэж байна. Хамгийн олон жижиг, дунд бизнес энд идэвхтэй ажилладаг. Тэгэхээр энийгээ дэмжиж байгаа юм. Нөгөө Жижиг, дунд үйлдвэрийн гэдэг маань өнгөрсөн 2000 оноос бодлого яваад ингэж хэрэгжүүлж авсаар байгаад хэмжээ нь багассаар байгаад үндсэндээ ингээд жилийн 20 тэрбумын хэмжээнд 1 агентлаг үлдчихсэн байгаа шүү дээ. Тэрнээсээ түвшин ахиад бид нар том үндэсний 4 том хөдөлгөөн гаргаад ингээд хэрэгжүүлээд эхэлж байгаа юм. Үндсэндээ ЖДҮ-ийн газрын үүрэг нэлээн амжилттай хэрэгжлээ. Дараагийн том хөдөлгөөн салбар хооронд нь бодлогын уялдааг хангаад явж байгаа гэдгийг л.../минут дуусав/

С.Ганбаатар: Пунсалмаа гишүүн асуулт асууя. Сайд нар гишүүдийн асуултыг бас бичиж аваарай. Бас үлдээчихгүй шиг хариулаарай. Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас асууя. Хөдөө аж ахуйн салбарт бол өнөөдөр сүргийн бүтэц, тэгээд бэлчээрийн даац бол хэтэрсэн байгаа. Тэгээд ямаа голдуу нэлээн ингээд бэлчээрийг харахад борлож ингэж харагдаж байгаа. Энд бол ямаа ихсээд байна. Малчид маань бол ямааны ноолуураа илүү зах зээлд гаргахыг хүсэж байна. Ямааны ноолуураа бид нар онцлог нь зөвхөн угаагаад гаргаад байгаа байхгүй юу. Энийг угааж гаргаснаараа нэмүү өртөг бүтээх боломжоо манай Монгол Улс алдаж байна гэсэн үг.

Самнаж гаргах ямар бололцоо байна. Угаасан ноолуур, самнасан ноолуур 2-ын хооронд 1 тэрбум 1 их наяд төгрөгийн зөрөө гарч ирж байна. Энийг бол энэ ноолуурын салбарынхан техникийн зохицуулалтаар зохицуулна. Засгийн газрын тогтоол гарна гээд хүлээгээд байгаа. Энэ хойшлогдоод байна. 2024 онд гарч ирээд энэ зохицуулалтаар зохицуулагдах байсан. Хойшлогдсон. Энэ яагаад ингээд дахин дахин хойшлогдоод байна. Энэ манай Монгол Улсын нэмүү өртөгт бас их нэлээн боломжийг алдаж байна гэж ингэж тооцож байгаа.

2 дугаар асуулт нь болохлоор энэ Хөвсгөл аймагт бяслагийн үйлдвэр 20 тэрбумаар бяслагийн үйлдвэр хийх гэж байна. Яам чинь ийм ЖДҮ-лэл өөрсдөө хиймээргүй байна. Бодлого баримаар байх юм. Ховдын аж үйлдвэрийн паркт 35 тэрбум тавигджээ. Эдгээр энэ үйлдвэрүүдийг барьчхаад би сая ойлгох нь ээ хувьчлах гэж байгаа юм байна гэж ойлголоо. Зөв үү. Дараа нь хувьчлах юм байх даа. Болж өгвөл бид нар төрийн өмчит үйлдвэрийн газруудын тоог багасгамаар байна. Одоо араг 600 гаруй төрийн өмчит үйлдвэрийн аж ахуйн нэгжүүд бий болчихлоо.

3 дугаар асуулт нь болохлоор “Цагаан алт” хөтөлбөр. “Цагаан алт” хөтөлбөрийн сая бол нэлээн асуултыг нь асуулаа. Хэдэн төгрөгийн санхүүжилт энэ жилдээ тавигдах юм бэ. 2 дугаарт энэ хөтөлбөр хэрэгжсэнээрээ зөвхөн зээл авахаас гадна энэ үйлдвэрлэгч нарт тарифаар энэ импортын бараанаас хамгаалах бодлого, цаашилаад экспорт зэрэг энэ олон бодлогуудаар энэ хөтөлбөрүүдээ бид нар хамгаалах, дэмжих ёстой байгаа юм. Зээл өгөөд орхичихдог, нөгөөдүүл маань тэгээд л тендерт орохтой нь зэрэг тендертээ багцын шаардлага тавьдаг. Тендерт зөвхөн ганцхан бүтээгдэхүүн оруулж ирэхгүй багцаар оруулж ир гэдэг. Тэгээд 1 үйлдвэрлэгч бол нэг л бүтээгдэхүүнтэй байдаг. Бусад бүтээгдэхүүн нь байхгүй багцад бүрдүүлж чадахгүй ингээд

үйлдвэрлэгч нар хоцордог. Тэгэхээр энэ импортыг орлох тарифын бодлого, тэгээд цаашилаад экспортод энэ бүтээгдэхүүнээ гаргах, манайх бол ноос ноолуурын нэхээсгүй эдлэлийн үйлдвэрээр хивсний үйлдвэрээр экспортод бол гаргах бүрэн боломжтой. Хивс, нэхээсгүй эдлэл, цэмбэ энийг бол бид нар импортыг хамгаалж өгөх хэрэгтэй. Цаашилаад олон улсад гаргах энэ боломж бололцоогоо эрэлхийлэх хэрэгтэй. Энэ тал дээр ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа вэ.

С.Ганбаатар: Мал аж ахуйн салбарын бүтээмж, үр ашигтай холбоотой асуултуудыг асуулаа. Ингээд Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Үнэхээр сүргийн бүтэц дээр жоохон анхаарах хэрэгтэй болж байгаа. Мэдээлэл маягаар өгөхөд нийт мал сүргийн 38,1 хувь нь ямаан сүрэг, 45,5 хувь нь хонь, адуу 7,5, үхэр, 8,3, тэмээ 0,7 хувийг эзэлж байна. Монгол Улс саяхан үндсэндээ түүхийгээр нь нэлээн гаргадаг байсан. Эндээ нэлээн бодлогын өөрчлөлт явсны үр дүнд одоо 100 хувь ноолуур Монгол Улсад 100 хувь угаагдаж нэмүү өртөг үүсэж байгаа юм.

Одоо дараагийн шат буюу самнах зорилгын яам тавьж байгаа юм. Одоо энд албан ёсоор хэлье. Ирэх хавар гэхэд Монгол Улсаас зөвхөн самнасан ноолуур л экспортлогдоно. Угаасан ноолуурыг бид гаргахгүй. Бид угааж чадаж байна. Одоо бид самнаж чадна. Бүх үйлдвэр нь самнах хүчин чадал бүрэн суурилагдсан, боломж бий. Дараагийн түвшинд бид бүх самнасан ноолуураа бид ээрч буюу утас хийх ёстой. Дараа нь бид сүлжих, дараагийн эцсийн бүтээгдэхүүн рүүгээ явна. Нийт ноолуурын салбар гэхэд 404,3 сая долларын экспортын түвшинд байгаа. Энийг бид нар яг энэ дарааллаа хийж чадвал бид нар 1,6 тэрбум долларын экспорт хийх чадавч зөвхөн ноолуур дээр байгаа. Үүнтэй холбоотойгоор нөгөө бэлчээрийн асуудал, ямаа тоо толгойн асуудал. Энэ дээр ахиад л нөгөө тэжээлийн аж ахуйнуудыг

олон аргаар бий болгох, тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх, нөгөө олон толгой мал биш цөөн чанартай, ашиг шимт малаа авч үлдэх өвөлжүүлэх ийм бодлого руугаа л бид нар жоохон бодлогын өөрчлөлтүүдийг хийхээс өөр аргагүй байгаа. Тэр Хөвсгөл бяслаг гээд ийм зүйлүүд бол байгаа юм. Бодлогын гадуур гишүүдийн санаачилж оруулж ирсэн ийм жижиг жижиг төслүүд их байна. Энийг улсын төсөв авч явах бололцоогүй, тэгээд л хийгдээд дуусдаг. Тэгээд орон нутгийн хөдөө аж ахуйн газар орон нутгийн өмчийн хэмжээнд бид нар шилжүүлж өгдөг. Тэгээд орон нутаг нь цаанаа хэрхэн зохицуулах нь бүү мэд буюу энэ өөрөө тийм зөв зүйл биш юм байгаа юм. Ер нь аль болох бид нар гишүүдийн оруулсан энэ олон зүйл дээр бас хатуу зогсож байгаа. Амаргүй маргаан бас үүсэж байгаа. Зарим гишүүд их бухимдалтай байгаа. Гэхдээ ингэж болохгүй. Төвлөрсөн аж үйлдвэрийн парк кластер луугаа л гол хүчийг хаяхгүй бол ер нь болохгүй нь гэж. Тэгэхээр Ховд дээр мөн адилхан дэд бүтцийг нь хийгээд өглөө. Орон нутагт нь бид нар шилжүүлээд л өгнө. Тэгээд орон нутаг орон нутгийн өмчид газар үүсэх нь үү, хувьчлах нь уу, яах нь вэ дараагийн юмаа шийдэх байх. Тэгэхээр “Цагаан алт” хөтөлбөр маань өөрөө энэ 2028 он хүртэл хэрэгжих 1,5 их наядын хөрөнгө оруулалтыг энэ боловсруулах салбарт хийгдэнэ. Энэ бол их томоохон технологийн шинэчлэл. Өргөтгөл. Эргэлт дээр нэлээн бодитой дэмжлэг үзүүлээд манайх арьс шир ноос ноолуураа боловсруулалт нэлээн сайжруулна. Зөвхөн ноолуур биш. Бид нарын лимитэд Монголын ийм онцлог 2 бараа байна. Тэмээний ноос. 2 тэмээд бүхний 90 хувь Монголд байна. Тэмээн ноос их сайн бас үнэтэй зах зээл гарах бололцоо байна. Сарлагийн хөвөр байгаа юм. Бас их эвтэйхэн. Жилдээ 240 орчим тонн сарлагийн хөвөр гарч байгаа юм. Энэ бас үнэтэй зах зээл. Ноолуур, тэмээ, сарлаг гурваа нэлээн түлхүү явъя. Хонины ноосоо нэлээн сайжруулъя. Хонины ноос маань зах зээл жоохон

амаргүй байгаа. Гэхдээ бордоо хийгээд эхэлчихсэн. Бордоо, нөгөө талаас барилгын материалын дулаалгад ашиглах ийм 2 эко бүтээгдэхүүний юм нэлээн өргөтгөх ийм боломж байгаа. Энэ түвшинд бид нар энэ “Цагаан алт” хөтөлбөр хэрэгжинэ. Гадаад зах зээлээ тэлэхийн тулд бид нар гадаад харилцаанд нэлээн ач холбогдлыг өгөөд байгаа. Одоо 12 сарын эхээр бид нар Евро Азийн Эдийн засгийн холбоотой Монгол Улсын хөдөө аж ахуйн гаралтай 375 барааг гаалийн татваргүй, квотын хязгаарлалтгүйгээр нэвтрүүлэхээр үндсэндээ гэрээг эцэслэхэд бэлэн болоод байна. Нөгөө талаас бас 300 гаруй нэр төрлийн бараа Монгол Улсад бас яг ийм болзолтой орж ирнэ. Энэ дээр бид нар харилцан тохироо.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхбаяр сайд нэмэлт минут авъя.

Ж.Энхбаяр: Зарим бараа, ялангуяа бид нарын хэрэгжүүлж байгаа энэ онцлог дотооддоо үйлдвэрлэлээ нэмж байгаа өндөг, сүү, үр тариа, гурилынхаа зах зээлийг хамгаалж бид нар тарифтай байна. Бусдыг нь бид нар авна гэдэг маягаар. Энэ Евро Азийн хэлэлцээр хийгдэх юм бол 200 сая хүний зах зээлтэй Евро Азийн холбоонд манай хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүд амжилттай нэвтэрнэ. Энэ өмнө нь хамгийн багадаа 15, дээд талд нь 55 хувийн тарифын татвартай босготой байсан юм. Энэ тэглэгдэнэ гэдэг маань манай энэ хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүнд том боломж үүсэж байгаа юм. Яг ийм цаг үетэй залгаж энэ “Цагаан алт”, хүнсний хувьсгалын хөдөлгөөнүүд нэрийн доор үйлдвэржилтээ дэмжээд эхэлж байгаа юм. Хориоо гэдэг маань өөрөө малчдаа түүхий эд бэлтгэх системийг нь сайжруулаад өгч байгаа. Малчид маань зохион байгуулалтад ороод, малчдаа гаргаад ирсэн дээрээ үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн хийгээд зах зээл гэсэн энэ 4 бодлого чинь дандаа харилцан уялдаатай

бие биеэ нөхсөн ийм 4 бодлого хийгээд хэрэгжүүлэхээр ингээд явж байгаа юм.

С.Ганбаатар: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны гишүүдээс, Ганбаатар даргаас хүсэх юм байна. Төрийн худалдан авалт дээр дэмжиж өгөөч. Дотоодын бүтээгдэхүүнүүдийг. Энэ дээр Их Хурлын тогтоолын төслийг санаачлаад бүрэн шийдүүлчихмээр байна. Ялангуяа хууль сахиулах хүчний байгууллагууд байна. Ажил мэргэжлийн дулаалгын хувцаснууд байна, хүүхдийн цэцэрлэг хоол, үдийн цай хөтөлбөрүүд байна гээд маш олон зүйл буюу дотуур байрны хөнжил, ор дэрнээс авхуулаад дотооддоо хийх бололцоотой маш олон зүйл. Энэ мөнгө зараад бид нар үйлдвэрлэл босгож байна. Маш их татаас өгч, түүхий эдийн системийг босгож байна. Дэмжих юм дээр нь бас шийдвэр гаргаад өгвөл эхний ээлжид яах вэ, дотоодын үйлдвэрлэл авна гэдэг бодлогыг л худалдан авалтад хийгээд өгвөл энэ хаана хаанаа их зөв бодлого болох юм болов уу гэж бодож байна шүү. Баярлалаа.

С.Ганбаатар: Түрүүн Пунсалмаа гишүүний асуусан тэр хувьчлах гэж байна уу л гэж ярьж байна. Хувьчилна л гэж байна. Түрүүн тэгж би ойлгосон шүү. Тэрийгээ тэгвэл нягтлаарай, тодруулаарай. Ер нь бол ингээд төрийн төсвийн мөнгөөр юм хийчхээд, дараа нь үнэгүйдүүлж байгаад ингээд хувьчилдаг байдлыг бас бид анхаарах ёстой. Ингээд Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Төсвийн тоо эргүүлээд их сонирхолтой юмнууд харагдаж байгаа юм. Энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багц 70 тэрбум, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц 905 тэрбум. Тэгээд үүнтэй холбоотой жоохон тоонууд асуух гэсэн юм. 2023 онд 363 тэрбум байжээ. 2025 онд 905 тэрбум болжээ. 2,5 дахин нэмэгдсэн байна. Хүнсний үйлдвэрлэл 2,5

дахин нэмэгдсэн юм уу, үндсэн шалтгаан нь юу бол гэж.

2 дугаарт нь яамны төсөв 2023 онд 7,5, 2025 онд 15 тэрбум 2 дахин нэмэгдсэн байна. Газар, хэлтсүүдийн тоо нэмэгдсэн юм уу. Юу болсон бэ.

3 дугаар асуулт нь хувийн хэвшлийн татаас 555 тэрбум. Энэ бол бүр цочмоор их тоо. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт 555 тэрбум төгрөгийн татаасыг хэн авдаг юм бэ. Яаж шалгаруулдаг вэ. Малчид авдаг юм уу. Тариаланчид авдаг юм уу. Эсвэл нөгөө том газар авчхаад байгаа компаниуд авдаг юм уу.

4 дүгээрт нь нэг ийм нөгөө зарчмын суурь асуулт байна л даа. Энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр гээд энэ том салбар хэзээ татаасгүй амьдардаг ийм орчин үеийн 21 дүгээр зууны салбар болж хөгжих вэ. Бодлогын хувьд. Маши ноцтой харагдаж байна тоонууд нь. Улс даяараа хүн болгон эрчим хүчний жилийн алдагдал нь 350 тэрбум төгрөг хаанаас гаргаж авна гээд үнэ нэмнэ гээд бүгдээрээ санаа зовсон хэл ам бөөн юм болж байна. 355. Гэтэл хөдөө аж ахуй дээр татаас гээд 555 тэрбум төгрөг. Тэгэхээр энэ ингэж удаан явж байх боломж бол байхгүй. Хэрвээ ийм бодлоготой экспортоо дэмжинэ, юу гэдэг юм хүнсний үйлдвэрлэл дэмжинэ, тийм учраас гэх юм бол энэ бол мухардал руу аваачна гэж бодож байна.

Атрын 4 дүгээр аян дахиад 200 мянган гектар га ингээд тавих юм бол дахиад бөөн ажил болно. Дахиад мөнгө орох юм уу. Тэгээд энэ эдийн засаг чинь 80 хувь төрийн эдийн засаг болчихоод байгаа шүү дээ. Ерөөсөө сонгосон зам бүх юм ул сууриараа өөрчлөгдөж байгаа. Тэрний бас нэг том буруутай салбар нь бол хөдөө аж ахуй юм шиг энэ тооноос бол надад тэгж харагдаж байна. Энийг хамтарсан Засгийн газар ирэх жилүүдэд анхаарч ажиллахгүй бол буцаад сэхэл авч чадахгүй, эрчим хүчний тарифыг өчнөөн

олон 10 жил хүчээр яасаар байгаад дампууруулах гэж байгаа шиг яг иймэрхүү асуудал хөдөө аж ахуй дээр гарч ирэх нь ээ. Цаана нь ингээд их тийм шударга бус өрсөлдөөний ноцтой асуудлууд бол байгаа гэсэн мэдээлэл ирж байгаа юм.

С.Ганбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Жаахан улс төрийн л асуудал болчихлоо. Хөдөө аж ахуйн салбар хэрэгтэй юу, хэрэггүй юу гэж. Ковид гээд нэг айхтар зүйлийг бид туулсан шүү дээ. Дэлхийн улс орон бүх хилээ хаасан. Монгол Улс дэлхий ертөнцөд тусгаарлагдсан. Дахиад 1 сар бид нар хугацаа алдсан бол Монгол Улс картын бараанд шилжихээс аргагүй ийм хүнсний тооцоо хийж байсан. Би яг тэр ажлыг өөрөө удирдаж, зохион байгуулж байсан. Монгол Улсад хүнсний нөөц, хүнсний хангамж алдагдсан байсан. Бүх юм импорт. Ямар ч юм байхгүй. Бүх хил, гааль бүрэн зогсдог юм байна лээ шүү. Гадаад орчин чинь хүндэрч байна. Дэлхийд өнөөдөр 900 гаруй сая хүн гэж байгаа юм. Өлсгөлөнтэй. 2 тэрбум гаруй хүнсний дутагдалтай. Дэлхийгээрээ хүнс дээрээ л анхаарч байна. Байгаль цаг уурын глобал өөрчлөлт явж байна. Бүх улс орон хүнс хийж, хүнсний төлөө дайн хийж байна.

Монгол Улс яах юм. Хүн ам 1 сая байхад бид нар байсан хөдөө аж ахуй чинь өнөөдрийн хүн ам 3,5 болчихоод 2030 онд 4 сая болох гэж байна. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж чадахгүй байна. Энэ салбар маань бас боломжийн экспортлогч болж байна шүү дээ. Зөвхөн 1 жилийн дотор манай экспорт 1 их наядаар нэмэгдлээ шүү дээ. Хөдөө аж ахуйн экспорт. Импорт 260 тэрбумаар багаслаа. Нийт Монгол Улсын ажиллах хүчний 1/2 буюу 600 мянган хүн энэ салбарт ажиллаж, амьдарч байна. Эндээс цалин хөлсөө олж байна. Энд бүх жижиг, дунд тэр үйлдвэрлэл явж байна. Энэ эдийн засгаас илүү улс төрийн их тогтвортой байдал,

нийгмийн тогтвортой байдал хангаж байгаа гол салбар болчихоод байна шүү дээ. Дэлхийн бүх улс орнууд хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбартаа татаас бодлогын дэмжлэгүүдийг хийж байна. Манайх байгаль цаг уурын таатай газар биш, маш чийгийн дутагдалтай, 4 улиралтай, хүйтэн сэрүүн өдөр, шөнийн градусын хэлбэлзэл ихтэй. Юм ургадаг, тарьдаг газар маань туйлын бага. Монгол улсын газар нутгийн 0,6 хувьд л юм ургаж байна шүү дээ. Үр тариа болж байна. 1 сая 500км газар нутаг маань 156 сая га газар байна үүний 1 сая буюу 0.6 хувь юм тарьж, ургаж байна. Энийгээ бид нар дээд зэргээр хамгаалах, хайрлах. Энийгээ бололцоог нь жоохон нэмэгдүүлэх л маш хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай байх л асуудал шүү дээ.

Хөдөө аж ахуйн салбарт 2 гол бүтээгдэхүүн урд явна. Ноолуур маань 400 гаруй сая доллар гарчихлаа. Нэмэх бололцоо байна. Мах маань 360, 370 сая хүрчихлээ. Нэмэх бололцоо байна. Энэ экспорт нь гадагшаа гарч байж нөгөө мал аж ахуй чинь идэвхтэй эдийн засгийн хувьд үр ашигтай болох хэлбэр лүүгээ орох гээд байна шүү дээ. Экспортлохгүй бол энэ дотооддоо байгаа л тоо өсөөд л бэлчээрээ талхлаад л өөрөө өөрийгөө амьдрах орчноо хязгаарлаад байгаа бүгд л мэдэж байгаа шүү дээ.

Нөгөө талаар уул уурхайгаас хэт хамааралтай Монгол Улсын эдийн засгийг олон тулгуурт болгоход хөдөө аж ахуйн салбараа, хөнгөн хүнсний үйлдвэрээ босгохгүйгээр өөр юу хийх юм. Аялал жуулчлалыг хийх гээд оролдож байна. Нааштай гарч байна. 800-1 сая хүн ирдэг болж байна. Нөгөө гол салбар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар шүү дээ. Монголын бүх ард түмний оролцоотой. Тэгэхээр энэ дээр та тийм улс төрийн хэрэгтэй, хэрэггүй биш. Энийг харин үргэлжлүүл гээд энэ Улсын Их Хурлаар чинь бодлого нь гараад батлагдаад явж байна шүү дээ. Зарим талдаа орж байна. Зарим нь

эхний 2 жил нь 1 жил нь явж байна. 4 том хөтөлбөр. “Цагаан алт”, хүнсний хувьсгал, хоршоо, Атрын-4. Энэ бодлогыг л бид урагшлуулъя л гэсэн ийм зорилготой 4 жилийн хугацаанд. Мэдээж хийх бодлого хууль, эрх зүйн боловсронгуй болгох зөндөө ажил байна.

Тэгэхээр энэ салбартаа их хандлага юмаа өөрчлөхгүй бол болохгүй гэж. Үгүйсгэж болохгүй. Өөр тэгээд бид юу хийх вэ гэж Та хэл дээ. Өөр юу хийх юм. Дайн болбол яах юм. Өвчин, тахал болбол яах юм. Газар хөдлөлт, гамшиг болбол яах юм. Ард түмнээ эрүүл аюулгүй баталгаат хүнсээр хаанаас хангах юм. Саяхан л би нар гаднаас хүнс гуйж байсан шүү дээ.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн тодруулъя.

Ж.Золжаргал: Хөдөө аж ахуй, хүнсний салбарын чухлыг ойлгож байгаа. Яагаад төсөв 2,5 дахин, яамны төсөв 2 дахин нэмэгдсэн бэ. Цаашидаа ингээд дандаа ийм татаастай явах юм уу? Тийм бие даасан байдлаар явах бодлого байгаа юу гэж.

С.Ганбаатар: Энхбаяр сайд хариулъя. Тодруулъя.

Ж.Энхбаяр: Манай экспорт 1 жилд 1 их наядаар нэмэгдлээ. Хөдөө аж ахуйн экспорт. Импорт 250, 260 тэрбумаар багасаж байна. Үзүүлэлтүүд гараад эхэллээ шүү дээ.

Монголчууд тарьдаг, ургуулдаг, үйлдвэрлэдэг, экспортолдог болж байна шүү дээ. Тэгээд энэ хөтөлбөр болгон чинь өөрөө хугацаатай байхгүй юу даа. 4 жил, 5 жилийн хугацаатай. Энэ хугацаанд л энэ үйлдвэрүүд салбаруудаа босгоё гэж байна. Хөлд орууъя. Эрийн цээнд хүргэх. Жишээлбэл Дархан дээр гэхэд дэд бүтцийг нь тавиад өгье. Цэвэрлэх байгууллагыг нь бариад өгье. Ингээд хувийн хэвшил маань хийгээрэй. Энэ хөнгөлөлттэй зээлээр ингээд өгөөдөхье, хүнсний үйлдвэрүүд маань технологио

шинэчлээрэй. Сав баглаа боодлоо сайжруулаарай. Энэ хүлэмжийн аж ахуй хөгжжөөсэй, ногоо тариалалт, усжуулалтаа хийгээсэй гээд дандаа дэмжлэгийн юм. Үнэн дэмжлэг. Гэхдээ хугацаатай. Энэ Их Хурлын бүрэн эрх хугацаанд энэ дэмжлэг үргэлжлээд л 2028 он гэхэд үр дүнгээ бид нар ард түмэн тавих байх. Тэгээд цаашидаа энийг.../минут дуусав/

С.Ганбаатар: Д.Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Надад 2 асуулт байна. Ингээд өвөл хаяанд ирлээ. “Тавантолгой түли” гээд нэг компани байгаа. Энэ “Тавантолгой түли” компанийн энэ асуултад хэн хариулах юм. Хотын захиргаанаас хүн байгаа байх гэж найдаж байна.

“Тавантолгой түли” компани хотын захиргаанд шилжиж ирсэн. Бид нарт өгсөн мэдээллээр 990 гаруй тэрбумын өртэй, 600 тэрбумын алдагдалтай ажиллаж байгаа. Дээрээс нь хамгийн аймшигтай нь энэ үйлдвэрлэлийн технологи бол алдагдсан байгаа. Энийг бол хаа сайгүй хүлээн зөвшөөрсөн. Ингээд энэ өвөл 300 мянга гаруй Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийг түлшээр хангана. Тэгээд нийслэл Улаанбаатар хотод очоод ямар нэгэн шинэчлэлийн зүйл хийгдсэн үү. Энэ алдагдаад байгаа үйлдвэрлэлийн горим дээр ямар арга хэмжээ авсан бэ.

2-т гэвэл Хавдар судлалын үндэсний төвийн захирал Эрдэнэхүү гэдэг доктор бол ярилцлага өгсөн байсан. Энэ дээр энэ шахмал түлшнээс үүдэлтэй шинэ төрлийн мутуацлагдсан элэгний хорт хавдраар зөвхөн Монгол хүмүүс өвдөж байна гээд. Тэгээд энэ элэгний хорт хавдраар өвчилж байгаа хүмүүсийн тоо улам нэмэгдээд байгаа. Тэгэхээр энэ жил энэ “Тавантолгой түли” гэдэг энэ компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж чадах уу. Энэ өр ширийн асуудал нь ямар болсон юм бол. Тэр технологийн

горим алдагдсан энэ дээр ямар арга хэмжээ авах, ямар бодлогын өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн бэ гэсэн 1 дүгээр асуулт байна.

2 дахь асуулт бол ирэх оны эдийн засгийн өсөлтийг 8 хувь болгоно гээд нэлээн өөдрөгөөр төсөөлж орж ирсэн. Тэгээд нөгөө “Тогтвортой хөгжлийн төлөөх зориг” гэсэн хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр явж байгаа. Энийг бол бид нар нэгэнт хамтарсан учраас дэмжсэн. Гэтэл мэргэжлийн байгууллагууд болох Монголбанк, тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засгийн яамнаас гаргасан энэ тайланг харлаа л даа. Энэ дээр болохоороо хэтэрхий өөдрөгөөр төсөөлсөн байна. Бодит байдалтайгаа яагаад санал нийлээгүй ингээд 8 хувиар төсөөлж орж ирсэн юм бэ. Ер нь бол эдийн засгийн өсөлтийг өнгөрсөн 3 жилийн хугацаанд ковидоос хойших эдийн засгийн өсөлтийг харж байхад 5 хувьтай өсөх болов уу гэсэн ийм төсөөллийг мэргэжлийн байгууллагууд хийсэн байна. Тэгээд ер нь манай Монгол Улсын энэ хөгжлийн ганц гарц, гаргалгаа нь бол экспорт, нүүрсний экспорт байгаа шүү дээ. Тэгээд энэ жил ирэх жил бол 83 сая тонн нүүрс худалдаалах юм байна. Тэгээд энэ худалдаалах бодлогоо энэ тооцооллоо хийсэн байх гэж бас найдаж байна. Тэгээд яагаад ингээд эдийн засгийн өсөлтүүд нь ингээд ийм зөрүү мэргэжлийн байгууллагууд ийм үгнэлтийг өгөөд байна вэ гэсэн нэг асуулт байна.

Дээрээс нь 83 сая тонн нүүрс экспортлох юм бол манай зам тээврийн асуудал ер нь ямаршуухан байдалтай байгаа юм. Салбар хоорондын уялдаанууд ер нь хэр зэрэг зохицолтой явагдаж байгаа вэ. Жишээлбэл нүүрс гарч байгаа энэ Гашуунсухайт, Ханги, Мандал, Шивээхүрэнгийн боомтуудын хилийн боомтын нэвтрүүлэх, нэвтрэх боломжийг нэмэгдүүлсэн үү. Энэ дээр дахин шинэчилсэн ийм бодлого өөрчлөлтүүд хийж байгаа юу. Мөн энэ Хятад улсын.../минут дуусав/

С.Ганбаатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны тайланд тийм зүйл байхгүй шүү. Эдийн засаг, хөгжлийн яам маань эдийн засгийн өсөлт маань 8 хувь гэж гаргасан байдаг. Энд одоо бид санхүүгийнхээ болон төсвийнхөө төлөвлөлтийг энэ хүрээнд хийгээд явдаг гэсэн үг. Өнгөрсөн 7 хоногт Олон Улсын Валютын сангаас гаргадаг улирлын нийтлэл ирэх жилийн форкаст дотор Монгол Улс 7 хувь байна гэж гаргасан. Сүүлийн 34 жилийн хугацаанд Олон Улсын Валютын сан анх удаа Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг ингэж өндөр тооцоолсон байна. Тооцоолсон байгаа. Тийм учраас бид нар аль болох энэ өсөлтийн төлөвлөлт энэ бүх юмаа аль болох эрсдэл багатайгаар ингээд гүйцэтгэлээ анхаараад явах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл аливаа эдийн засгийн өсөлт, эдийн засгийн тэлэлт эрсдэл дагуулдаг. Инфляц болон бусад эдийн засгийн агрегатууд дээр сөрөг дарамтууд ирнэ. Гадаад валютын нөөц дээр ирнэ, импорт дээр ирнэ, гадаад худалдаа дээр ирнэ. Харин бид нар орцоо цаг хугацаатайгаа хэрхэн яаж тохируулж явах вэ л гэдэг бидний дараагийн сорилт руугаа орж ирж байгаа байхгүй юу. Өнгөрсөн 4 жил бол бид ер нь бол дутуугийн өндөр эрсдэлтэй байсан. Ойрын 2, 3 жилийн хугацаанд эдийн засаг өсөөд, тэрийг дагасан эдийн засгийн халалт, энийгээ зохицуулалт хийх ийм эрсдэл болон сорилт бидний өмнө тулгарч байна гэсэн үг. Энэ сорилтоос бид нар болгоомжлоод, буцаагаад бүх юмаа хумиад ингээд эдийн засгийнхаа үзүүлэлт, төсвийнхөө үзүүлэлтүүдийг хамгийн сайхнаар гаргаад явахад болно л доо. Гэхдээ эдийн засгийн өсөлт байхгүй болно. Дараа дараагийн бид нарын эдийн засгийн өсөлтүүдийг боомилж байгаа нөгөө нэг сэргэлтүүдээ бид нар хийж чадахгүй болно. Эрчим хүчнийхээ сэргэлтийг хийж чадахгүй болно. Энэ зам тээврийнхээ сэргэлтийг хийж

чадахгүй болно. Өнөөдөр бид нар ямар ч хувийн хэвилийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгуулагдлаа гэхэд бидэнд эрчим хүчний маш том хязгаарлалтад орчихсон байгаа. Улаанбаатар хотод нэг ч шинэ үйлдвэр, нэг ч шинэ орон сууц, хороолол байгуулагдах бидэнд нэмэлт эрчим хүчний эх үүсвэр байхгүй болчихсон байгаа.

Тийм учраас одоо олж авсан үзүүлэлтүүдээ хамгийн сайнаар нь улам сайжруулаад л эдийн засгаа агшаагаад л, бариад л төсвөө ашигтай гаргаад л, төлбөрийн тэнцлээс бүгдийг нь ашигтай гаргаад яваад байх нь их амархан л даа. Энэ сонголтын л асуудал байгаа. Сонголтын асуудал байгаа. Ирэх жилийн 10,3 их наяд хөрөнгө оруулалт, төсвийн алдагдал 1,9 их наяд маш амархан. Хөрөнгө оруулалтуудаа татаад л тэнцлээ маш аятайхан болгож ирээд л бүх үзүүлэлтүүд маш сайхан шүүгээд ингээд хөгжлийн хурд удааширна. Нөгөө бид нарын 10 жил ингээд суусан бид нар өөрсдийгөө ингээд эдийн засгийн боломжуудаа алдсан энэ юм маань ингээд л царцаад л үргэлжилнэ л гэсэн үг. Бид нар ийм л сонголтын зааг дээр ирчихсэн байгаа л гэж хармаар байгаа юм.

83 сая тонн гэж байна ирэх жил. Энэ жил ер нь бараг 80 гарчих байх. Одоо явж байгаа энэ хурдаараа бол. Тэгэхээр өөрөөр хэлбэл манай боомтын нэвтрэн өнгөрүүлэх чадвар бид нар ийм хэмжээнд ирсэн байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл энэ жил гаргах гэж байгаагаа л хойтон гаргах гэж байна гэсэн үг. Тийм учраас бид өнгөрсөн 4 жилийн хугацаанд энэ шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ялангуяа боомтын сэргэлтийн хүрээнд энэ боомтын нэвтрэн өнгөрүүлэх чадвар, ялангуяа цаад талын боомтуудтайгаа бид угсрагдаж хүлээн авах чадвартай нийцүүлж гаргаж чаддаг ингээд нэг ахиад байгаа байхгүй юу. Боломжийн хэмжээнд ингээд ахиад байгаа юм. Энэ хүрээнд бид нар гаргаж чаддаг болжээ. Энийг улам сайжруулах, ойрын

хугацааны төлөвлөлтүүдийг Боомтын сайд Тулга байж байна. Бас нэмж хариулбал их сайн байна. Тийм учраас ирэх жилийн нүүрсний энэ тоо бол өөдрөг, биет хэмжээ нь бол өөдрөг биш, харин ч бага байгаа юм. Ирэх 4 жилийн хугацаанд бол энийг 120-оос доошгүй сая тонн ийм биет хэмжээг гаргана гэж зорино. Бид нүүрсний экспорт хийх үүлэн чөлөөний ойрын хугацаанд 5-10 жилийн хугацаа л байгаа. Тэрнээс цааш ер нь энэ урд хөрш маань эрчим хүчний нүүрсээ ер нь бараг авахгүй болох байх.

С.Ганбаатар: Тулга сайд хариулъя.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрвэ. Яг 10 сарын 1-ний байдлаар статистик би бас эндээс харж байна. Ингээд 60,6 сая тонн нүүрс ер нь манай экспортын 60 хувь гэсэн үг шүү дээ тийм ээ. Орж ирж байгаа валютын нөөцийн. Тэгээд 60,6 сая тонн нүүрсийг 10 сард, үлдсэн 3 сард үндсэн жилийнх нь динамикаар өсдөг. Энэ тоо бас өсөлттэй байгаа. Тэгэхлээр 80 сая тонн бол энэ жилдээ гарчихна. Тэгээд тэрийгээ сайдын хэлснээр ирэх жил төлөвлөсөн байгаа. Нэмж тавиагүй. Нэмэгдээд Гашуунсухайт боомт бол сая баригдаад дууссан. Сая 10 сарын 15-аас эхлээд цогцолборын хувьд бол дулааныг нь өгөөд, туршилтын шугамаар явж байна. 11 сарын эхээр Гашуунсухайт боомтын шинэ цогцолборыг ашиглалтад оруулж хүлээж авахаар ажиллаж байна. Замын-Үүд цогцолборыг бол энэ жилийн эхэнд бүрэн ачаа тээврийн цогцолборыг ашиглалтад оруулсан. Дээр нь нэмээд Замын-Үүд цогцолборыг урт хугацааны туршилт буюу 24 цагаар ажиллуулж, шөнийн цагаар уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох ийм үйл ажиллагааг туршсан байгаа.../минут дуусав/

С.Ганбаатар: Тулга сайдад нэмэлт минут өгье.

Б.Тулга: Эдгээр нь бол бидний БНХАУ-д экспортлох уул уурхайн

бүтээгдэхүүнийг гаргах дэд бүтцийг бий болгох дээр бас хийж байгаа ажлууд гэж ойлгож болно. Зүүн талаар зүүн бүсээр Сүхбаатар аймгийн Бичигт боомтоор нүүрс экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Уул уурхайн технологийн зам баригдаж байгаа. Цогцолборын бүтээн байгуулалтын ажил бол одоогийн байдлаар 20 орчим хувийн гүйцэтгэлтэй явж байгаа. 2025 оны 12 сард дуусах төлөвлөгөөтэй явж байгаа.

Шивээхүрэн боомтын хувьд бол үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бол Шивээхүрэн боомтыг өргөжүүлэх, тэнд чингэлэг тээврийн терминал, боомтын төмөр замын бүтээн байгуулалт, жолоочгүй тавцан тээврийн терминалууд гэх мэтчилэн тээврийн шинэ төрлүүдийг хилийн боомтоор барьж ашиглалтад оруулсан байгаа гэдгийг энэ таширамд хэлье. Тэгэхээр 2025 онд зорьж байгаа энэ эрдэс баялгийн худалдааг БНХАУ-тай хийхэд дэд бүтцийн хувьд болбол одоо байгаагаас өшөө нэмэгдүүлэх ийм ажиллагааг хийж байна гэж үзэж байна.

С.Ганбаатар: Тулга сайд.

Б.Тулга: Энэ Та бүхэнд нэг мэдээлэл өгөхөд төсөв өргөн барьж байгаа энэ үед бол БНХАУ-ын Засгийн газраас бас Хятадын дунд бүтцийн салбартаа буюу энэ салбарын уналтыг бас зогсоож, 2025 оныхоо 5 хувийн өсөлттэй нийцүүлэхийн тулд 10 их наяд долларын 10 иений шүү. 10 их наяд иений бас иен биш юань. 10 их наяд юанийн хөрөнгө оруулалтыг Засгийн газраасаа бас энд Хятадынхаа дэд бүтцийн салбар луу бизнес салбар луу хийх ийм шийдвэрийг бас өчигдөр, уржигдар Хятадууд маань гаргаад зарлаж байна. Энэ нь бол манайд бас шууд нөлөөтэй. Ялангуяа дэд бүтцийн салбар луу ийм хэмжээний юу хийнэ гэдэг бол бид нарын бас төлөвлөж байгаа уул уурхайн бүтээгдэхүүн бас унахгүй байх

ийм аятайхан мэдээ ирж байна гэдгийг бас энэ таширамд та бүхэнд хэлчихье.

Цагаан Дэл уулын бүтээн байгуулалтыг бол Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орчихсон. 2014 оноос яригдаж байгаа боомтын бүтээн байгуулалтыг хийнэ. Замаа бас бид нар ашиглалтад оруулах ёстой. 2025 оны төлөвлөгөөнд.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд тодруулъя.

Ц.Туваан: Боомтын нэвтрүүлэх чадвартай холбоотой энэ Гашуун сухайт-Ганц мод төмөр замын холболтын ажлын хэсэг явж байгаа. Тэгээд ойрын хугацаанд бас Их Хурал руу энэ асуудал бол орж ирнэ. Энэ төмөр замыг хамгийн эхэнд холбоод, дараагаар нь Ханги Мандалын төмөр зам, Шивээ хүрэн-Сэхээгийн төмөр зам, тэгээд Бичигт Хатавчийн гээд дэс дарааллаараа энэ төмөр замын холболтууд хийгдэж байж нүүрсний экспортын хэмжээ тэр 120 саяас давах хэмжээндээ хүрнэ гэдэг мэдээлэл өгье.

Тэгээд ойрын хугацаанд бас Их Хурлаар орж ирнэ. Тэгэхээр энэ дээр манай Аж үйлдвэрийн байнгын хорооны гишүүд бас энэ асуудлыг тухайн үед нь бид нар нэмэлт мэдээлэл өгнө бас дэмжиж өгөөрэй. Тэгвэл энэ нүүрсний экспорт чинь бодитойгоор өндөр хэмжээнд хүрнэ.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Баярлалаа. Сайдууд уралдаад л ерөнхийдөө маш өөдрөг хариулт өглөө. Тэгээд ер нь үндэсний болон энэ орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тээврийн компаниудаас миний авсан мэдээлэл бол нөхцөл байдал хүнд байна гэсэн ийм мэдээллийг өгсөн юм. Тэгээд би асуулаа. Тэгээд ямар ч байсан энэ өөдрөгөөр хараад 83 сая тонн

нүүрсийг бол экспортлох юм байна гэсэн ойлголт авлаа.

2 дахь асуултынхаа хариултыг авъя. Хотын захиргаанаас хүн байна уу. Тэр “Тавантолгой түлш” компанийн асуудлыг энэ жил ямар нэгэн бодлогын өөрчлөлт хийсэн үү. Тэр маш хүнд байдалтай өвлийг угтаж байна даа бид нар. Хотоос хүн байсан шүү. 2 хүн байсан. Хариулт өгье. Улаанбаатар хотын захиргаа. Жаргалсайхан гишүүн асуулт асууя. Тэр Улаанбаатар хотын нөхрийг дуудаарай. Ийм арчаагүй байж болохгүй шүү.

Д.Жаргалсайхан: Тэрийг өнөөдөр бас энэ Байнгын хорооны хурал дээр бас нэг хүнд баяр хүргэмээр санагдлаа. Энхбаяр сайддаа баяр хүргэе. Бид нар олон жил ярьсан да. Тэгээд л хотоосоо нүүнэ, энэ сургуулийг ч нүүлгэнэ, яамандаа ч нүүлгэнэ гээд. Хөдөө аж ахуйн яам бол Дархан руу нүүчихсэн байна. Тэгээд энэ бол бас ажил шүү. Танд баярлалаа бас амжилт хүсье. Нэг их олон ажил бид нар ингээд л ярьж байгаа. Яг ажил болдог юм бол цөөхөн байдаг шүү. Тэгэхээр Дархан руу нүүнэ гэдэг бол эхлэл. Дарханы арьс ширний үйлдвэр баригдаж байж Монгол Улсын энэ малын гаралтай түүхий эдийг боловсруулах асуудал яригдана. Тэр тусмаа арьс ширийг боловсруулахад 9 химийн бодис, 6, 7, 8, 9 ч химийн бодис. Тэр химийн бодисыг саармагжуулах асуудал үнэхээр чухал юм байгаа юм. Тийм учраас энэ яагаад Дарханд яагаад тэр цэвэрлэх байгууламж гэдэг асуудал ингэж яригдаж байгаа. Тэгэхээр тийшээ яам очсон. Тийм учраас энэ үйлдвэр бол нэлээн эрчимтэй явах байх гэсэн ийм итгэл үнэмшил бол төрж байна.

Мөн дээрээс нь бидний хувьд олон ажил арга хэмжээнүүдийг хийнэ гээд төсөв дээр суусан байна. Мөн дээрээс нь саяын тэр татаас гээд ярьж байгаа юм. Татаас дээр ноолуур дээр бидний хувьд яг хэдэн төгрөгийн татаас, хүүгийн татаас өгч байна вэ. Байхгүй юу. Тэгвэл

ноолууран дээр өгмөөр байгаа юм. Яагаад энийг хаячхав. Жишээ нь Хятад бол ямар ч хүүгүй зээл өгөөд л явуулж байгаа шүү дээ. Тэгэхэд манайх хэдэн хувийн зээл, яаж өрсөлдөх юм. Яаж тэр ноолуураа 100 хувь энд нь угаагаад самнаад, самнана гэдэг чинь жилийн хугацаанд явж байгаа үйл ажиллагаа шүү дээ. Тэгээд 2023 онд бид нар 100 хувь самнана гэсэн байхгүй. 2024 онд самна гэсэн байхгүй. Одоо хэдий хугацаа, хэзээ эхлэх юм бэ. Тэгээд энэ дээр ямар бодлого байгаа юм. 1 дэх асуудал.

Дараагийн асуудал манайх нөгөө Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо гээд байж байгаа юм. Энэ ерөөсөө л ойлгомжтой асуудал байгаа юм. Бид нар ерөөсөө экспортод гаргаж байгаа нийт бараа бүтээгдэхүүний 93 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн. Дандаа түүхийгээрээ гарч байгаа юм. Энийг боловсруулах асуудал л яригдаж байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн бидний энд сууж байгаа энэ Байнгын хорооны манайд харьяалагдаж байгаа 2 яамны гол асуудал бол ерөөсөө л аж үйлдвэрлэлийн салбарт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг л зорьж байгаа юм. Энэ дээр Уул уурхайн сайдаас асууя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас. Яг ямар бүтээгдэхүүнээ боловсруулах гэж байгаа юм бэ. Эцсийн бүтээгдэхүүн болгох гэж байгаа юм бэ. Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Ямар төсөв мөнгө энд тавигдсан юм.

Дараагийн асуудал өмнөх сайдын үед энэ хайгуулын лицензийг дуудлага худалдаа буюу хамгийн өндөр үнийн санал өгсөн хүнд өгч байсан.../минут дуусав/

С.Ганбаатар: Эхлээд Энхбаяр сайд хариулаад, дараа нь Туваан сайд хариулах юм байна.

Ж.Энхбаяр: Жаргалсайхан гишүүнд баярлалаа. Урам өгсөнд. Ноолуур дээр энэ татаасны ямар нэгэн хэлбэр байхгүй. Харин хөнгөлөлттэй зээл ноолуур дээр

гол одоо ачааг авч байгаа. Эргэлтэд нь өгөөд байгаа. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд энэ жил 300 тэрбум төгрөгийн зээл гарч байгаа юм. Үүний 230 тэрбум нь ноолуурын салбарт гарч байгаа юм. Тэр хүүгийн хөнгөлөлт дээр л төсөв дээр мөнгө тавиад л хүүг нь хөнгөлөөд л ноолуурын салбарын эргэлтийг дэмжих буюу нөгөө гадаад зах зээлээс өсөлтийг дотоодод орж ирж худалдан авалт хийж байгаа дээр Монголын аж ахуйн нэгжүүд эх үүсвэргүй байхгүй гэдэг талаас нь дэмжээд, хөнгөлөлттэй зээлээр дэмжээд яваад байгаа юм. Тэрнээс бол тушаасан ноолуурт ямар нэгэн урамшуулал малчид болон аж ахуйн нэгжид байхгүй. Эргэлтийн зээлээр дэмжиж байгаа. Ахиад хэлье. 100 хувь бид нар угааж байгаа. Одоо 100 хувь самнана. Самнаагүй ноолуурыг гаргахгүй. 2025 онд. Засгийн газраас өмнө Засгийн газар 2 жил хойшлуулсан. Энэ дээрээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дахин ийм зүйлийг үүсгэхгүй. Дотооддоо нэмүү өртгийг бий болно. Ер нь үйлдвэрлэдэг болж байж л улс орон хөгжинө. Тэгэхээр боломж байна. Ноолуураа бид нар 100 хувь угааж, самнаж, ээрч, сүлжих бололцоо байна. Тэгэхээр энэ чиглэл рүү л бид нар цаашидаа улам цаашидаа л бодлогоо чангаруулаад л явна.

С.Ганбаатар: Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Мэдээж аж үйлдвэрийн салбар бол хамгийн их ажлын байр нэмүү өртгийг бий болгодог ийм салбар. Тэгэхээр мэдээж бүтээгдэхүүнээ түүхийгээр биш боловсруулж байж нэмүү өртөг шингээж, ажлын байрыг бий болгох ёстой гэдэг энэ Жаргалсайхан гишүүний саналтай бол 100 хувь санал нэг байна. Манай дээр бол үндсэн 7 бүтээгдэхүүн, уул уурхайн бүтээгдэхүүн, энэ дотор нүүрс, зэс, төмрийн хүдэр, жонш, тэгээд цайр, газрын тос мөн дотооддоо Монголбанканд тушаагдаж байгаа алт гээд ийм бүтээгдэхүүнүүд

байгаа. Тэгэхээр энэ бүтээгдэхүүнийг бид бүхэн аль болох эцсийн бүтээгдэхүүн болгох зорилгоор зорилго тавин ажиллаж байгаа. Тэгээд ийм ч учраас бас яамныхаа бодлогыг энэ чиглэлд хандуулж байгаа.

Үйлдвэр технологийн паркийн тухай хууль батлагдсан. Энэ хуулийн дагуу үйлдвэр технологийн паркуудыг үүсгэх замаар энэ асуудал дээр үйлдвэрүүдээ бариад явна. Хамгийн түрүүнд зэс хайлуулах үйлдвэрийн цогцолборыг.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайдад нэмэлт 1 минут.

Ц.Туваан: Барих ийм зорилттой явж байгаа. Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалыг түшиглэж 760 сая долларын хөрөнгө оруулалт шаардсан ТЭЗҮ-тэй. Дараагаар нь бол ган боловсруулах үйлдвэр мөн нүүрс дээр нүүрс угаах, дээрээс нь кокс үйлдвэрлэх гэсэн ийм чиглэлээр. Жонш дээр гэхэд бол жоншийг баяжуулж олон улсын стандартад нийцсэн 9 5 хувийн агуулгатай баяжмал үйлдвэрлэх чиглэлд гэсэн ийм дэс дарааллуудаар явж байгаа. Энэ дээр бол төсөв дээр тавигдсан ямар нэгэн хөрөнгө, мөнгө байхгүй. Энийг гаднын хөрөнгө оруулалтыг оруулж ирж хувийн хэвшилтэйгээ хамтарч хийх ийм байдлаар зохицуулахаар ажиллаж байгаа.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Ер нь манай 2 яам ямар байдлаар орлого улсын төсөвт төвлөрүүлж байгаа вэ. Жишээ нь өмнө нь хайгуулын лицензийг хамгийн өндөр үнийн санал өгсөн аж ахуйн нэгжид олгож байлаа шүү дээ. Энэ удаа бас яг тийм зүйл давтагдах уу. Энэ ямар журмаар, ямар хуулиар сумынх нь Засаг дарга мэдээгүй, аймгийнх нь Засаг дарга мэдээгүй, иргэд нь мэдээгүй байж байхад шууд танайд ийм ийм газар нутгийг лицензээр олгосон байна гээд мэдэгдэх

хуудас ирж байгаа юм. Тэгэхээр энэ ямар байдлаар ийм хуулийн заалт, ямар журмаар ингээд явчлав. Энэ цаашаа үргэлжлэх үү. Тэгээд 2 яаман дээр хоёул дээр нь ямар орлого төвлөрүүлэхээр тусгагдсан байгаа вэ. Хаанаас тэр орлого эс үгүй бол тодорхой бол. Ийм зүйлийг асууя.

Мөн дээрээс дахиад нэг юм асуучихъя Туваан сайд аа. Ингээд Хөдөө аж ахуйн яам нүүчихлээ. Танай яам нүүх боломж байна уу. Жишээ нь Эрдэнэт РҮҮ.

С.Ганбаатар: 2 асуулт асуулаа. Эхлээд Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Түрүүний хайгуулын лицензтэй холбоотой асуудал дээр би бас дутуу хариулсан байжээ. Энэ одоогоор бол лиценз олголт зогссон байгаа. Засгийн газраас лиценз олголтыг энэ ондоо багтааж журмыг нь шинэчлэн боловсруулж, нээх ийм чиглэлтэй ажиллаж байгаа. Мөн эцсийн шийдвэрийг Засгийн газар дээр гаргаад явах ийм чиглэлтэй ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд улсын төсөвт 86,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төвлөрүүлсэн байна.

С.Ганбаатар: Энхбаяр сайд тодруулъя.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуйн яам өөрийн төвлөрүүлэх орлого гэж байдаггүй . 100 хувь улсын төсөв дээр суурилж байгаа. Манай харьяанд 2 улсын төсөвт үйлдвэрийн газар байгаа. Энэ нь өөрөө өөрийнхөө орлогоороо өөрийнхөө үйл ажиллагаагаа санхүүжүүлээд явдаг. Хөдөө аж ахуйн бирж, Хөдөө аж ахуйн корпорац гэсэн 2 улсын тооцоот үйлдвэрийн газар байгаа.

С.Ганбаатар: Би хэдэн асуулт асуучаад тэгээд үндсэндээ хүнд үйлдвэрийн яам, Хөнгөн үйлдвэрийн яам бодлого тодорхойгүй байгаа. Бодлого хэзээ тодорхой болох вэ. Бид чинь хөнгөн

үйлдвэр, хүнд үйлдвэрээ тодорхойгүй байхад яаж дэмжих гээд байх вэ дээ. Хэн нь хүнд юм, хэн нь хөнгөн юм. Тодорхойгүй. Хэзээ гарах вэ.

2 дугаар асуулт. Хүнд үйлдвэрийн, хөнгөн үйлдвэрийн хууль тогтоомжууд хэзээ бэлэн болох вэ. Энэ чинь хариуцаж байгаа яамд нь энэ дээр хөдлөхгүй байвал энэ чинь болоод байгаа гэсэн үг үү. Эсвэл бодлогоор эсэргүүцээд байгаа гэсэн үг үү. 2 дугаар асуулт 2 яамнаас хоёулангаас нь.

3 дугаар асуулт. Сангийн яам хариулах юм болов уу. Нэг орноос нэг бүтээгдэхүүнээр 100 хувь орчим хараат байхад бусад аж үйлдвэрлэгч нарт нөлөөлөх үү. Нөгөө солонгоруулна, төрөлжүүлнэ гэдэг аж үйлдвэрлэлийн бүтээмжийн бодлого хаашаа явсан бэ. Хаачсан бэ. Энэ дээр та нар ямар нэгэн бодлого барьж байгаа юу. Энэ эрсдэл байхгүй юу. Эрсдэлийн тооцоо судалгаа хийсэн үү.

3 дугаар асуулт. Цахилгаан, дулаан нэмэгдэнэ. Нэмэгдэх нь тодорхой болчихсон. Та нар тэгээд хүчиндээд шийдэх юм шиг байна. Би нэмэхгүй гэж хэлээгүй шүү дээ. 1,8 их наядын төрийн өмчийн компаниудын алдаа, сул менежмент, бүр луйвар байж болох энэ асуудлуудаа нэг тийш нь болгож шийдэх талаар яагаад юу ч хөдлөхгүй байгаа юм бэ. Дамжуулан зээлийн 90 хэдэн оноос эхлүүлээд л 2000 он гараад л баахан зээл авсан. Дандаа доллароор. 500 төгрөг 1 доллар байхад л зээл авсан. Өнөөдөр 3400 болгоод 2900 төгрөгийг ард түмний нуруун дээр тавих гэж байгаа. Та нар цахилгаан дулааныг нэмснээрээ яг ард иргэд энэ аж ахуй эрхлэгчид, жижиг, дунд үйлдвэрлэгчид тэснэ гэж бодож байгаа юм уу. Энэ дээр Энхбаяр сайд судалгаа хийсэн юм уу, Туваан сайд энэ дээр танай хүнд үйлдвэр ингээд зүгээр нормаль явчих уу. Та нар тооцоо судалгаа хийсэн үү. Холбогдох тэр аж үйлдвэр эрхлэгчдийн төлөөллийн байгууллагуудтай уулзсан уу, ярилцсан уу. Бүр ярилцах үүрэгтэй шүү дээ хуулиараа.

Цахилгаан дулааны асуудлаар би ярьчихлаа.

5 дугаар асуулт. Сангийн яамнаас асуучихъя. Өнөөдөр чинь төсөв орж ирж байгаа юм шүү дээ. Энэ аймгууд дээр байгаа төсөв 1 аймаг дээр дунджаар 70, 80 тэрбум төгрөг тавигдаж байгаа. Орон нутгийг хөгжүүлэх сан гээд олон тэрбум төгрөг тавьж байгаа. Тендер, төсөл хөтөлбөрүүдээс яг тухайн орон нутагт байгаа аж үйлдвэрлэгч нар жижиг, дунд үйлдвэрлэгч нар ялангуяа мал аж ахуйн салбарын хөнгөн үйлдвэрийнхэн, хүнд үйлдвэрийнхэн, хүнд гэж яриад яах вэ. Мал аж ахуйн салбарынхан яг яаж ажлын байр бий болж байгаа вэ. Хэдэн хувь нь энэ төсвийн хэдэн хувь нь үр ашгаа өгч байгаа вэ. Тооцоо судалгаа хийсэн юм байгаа юу.

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1, 42 дугаар хууль гээд 1, 2, 3, 4 гээд хэрэгжилт 0 байгаа. Тухайн аймагт байгаа мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдийг л боловсруулахад зориулж ажиллах ёстой болоод хариуцлагаа үүрэх ёстой. 42 дугаар хууль дээр Ашигт малтмалын 42 дугаар хууль дээр тооцоо судалгаа үндэслэл хэд байгаа вэ. Хэдэн төгрөг яг энэ хүмүүсийг ажилтай болгох, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулахад зориулсан бэ. Судалгаа тооцоо байгаа юу. Хүнд үйлдвэрийн яам.

Эцэст нь Туваан сайдаас асуучихъя. Танай хариуцаж байгаа газар, хэлтсийн дарга нар Оюутолгойг долоохоо хэзээ болих вэ. Оюутолгойн Улсын Их Хурлаас гаргасан 103 дугаар тогтоолын дахиад зээлийн дарамтад Монголыг оруулахгүй гэсэн энэ зүйл заалт яагаад хэрэгжихгүй яваад байгаа юм. Тэр дээр та нар хяналт тавьсан уу. Би 3, 4 дүгээр зүйлийг нь асууж байна. Тэгэхээр Сангийн яамнаас асуух гээд байгаа юм. Оюутолгой ингээд зээл аваад байхаар манай төсвийн орлого энэ тооцоо судалгаанд нөлөөлөх юм

байгаа юу. Би ийм асуултуудад хариултаа авъя даа. 7 Асуулт.

Ганбат Төрийн нарийн бичгийн дарга.

Ж.Ганбат: Би яг Сангийн яамтай хамааралтай асуултуудад хариулъя. Яах вэ, бид түрүүн таны нэг улсаас гаралтай нэг бүтээгдэхүүнээ 100 хувь хараат байх нь бодлогын хувьд зөв үү. Энд Сангийн яам эрсдэл тооцож үзэж байсан уу гэдгийг нь бас энэ дээр яах вэ Туваан сайд бас хэлэх байх. Бид бол үнэхээр энэ газрын тосны бүтээгдэхүүний хувьд бол хараат бол бас олон жил явж ирсэн. Энийг бол үе үеийн Засгийн газар бол тодорхой хэмжээгээр зохицуулах гэж бодлогын хувьд бид эрсдэлийг бол урьдчилж тооцох гэж хэд хэдэн арга хэмжээнүүд авч ирж байсан. Нөөц бүрдүүлэх, татвараар зохицуулах, үнийг бол огцом өсгөхгүй байна энэ тэр гэдэг ийм арга хэмжээнүүдийг бол авч ирсэн. Тэгээд одоо бид газрын тосны үйлдвэр бол барьж байна. Энэ дээр бол яах вэ бид хамгийн гол зорилго бол газрын тосны бүтээгдэхүүний хараат бус байдлаас гарахын тулд газрын тосны энэ үйлдвэр бариад, яг одоо бол энийг хэрэгжүүлээд явж байгаа. Нөгөө талдаа яах вэ бид Бүгд найрамдах Хятад Ард улс, нэг улсаас биш бас өөр улсаас импортоор шатахуун оруулж ирэх асуудлыг бас Уул уурхайн яам судалж үзээд, энийг хэрэгжүүлж байсан ийм юмнууд байгаа. Энийг салбарын яам дэлгэрүүлээд хариулах байх гэж үзэж байна.

Аймгуудын орлогууд дээр бид бол сүүлийн үед ерөнхийдөө сүүлийн бараг 10-аад жил Засгийн газраас болон үе үеийн Засгийн газрууд бол орон нутгийг бол дандаа бие даалгахыг дэмжиж ирсэн. Орон нутгийг бол өөрөөр хэлэх юм бол тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг уул уурхай болон уул уурхайн бус аж ахуйн нэгжүүдийн орлогыг тодорхой хувиар орон нутагт нь үлдээх ажлын байр нэмэгдүүлэх. Энэ дээр хамгийн сүүлд авч

хэрэгжүүлсэн арга хэмжээ бол аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг нь бол тухайн аймагт үлдээж байгаа. Одоо яг энэ хүрээндээ бид энэ аж ахуйн нэгжийн орлогын 40 хувийг улсын төсөвт 100 хувь төвлөрдөг байсныг 40 хувийг нь орон нутагт үлдээсний гол зорилго нь тухайн орон нутагт ажлын байр нэмэгдэх, бизнесийн үйл ажиллагаа бол тухайн орон нутагт явах ийм зорилгоор гол юмнуудыг ингэж үлдээж байсан. Энэ бол яах вэ үр дүнгээ өгч байгаа. Гэхдээ яах вэ бүхэл бүтэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүйгээр, тодорхой нэг чиглэсэн арга хэмжээнүүдийг бол бид хэрэгжүүлээгүй. Яах вэ, эхний үеүдэд бол дандаа уул уурхайтай холбоотой бизнес дээр ашигт малтмалын нөөцийн төлбөр, лицензийн төлбөрийг орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан хуваарилж байсан. Сүүлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг бол үлдээлээ. Нөгөө талдаа бид яг энэ дээр дахиад дүгнэлт хийгээд үзэхээр бид ингээд ямар нэгэн байдлаар эх үүсвэр гаргаж өгөөд ингэхээр нөгөө талдаа бол бас ажиллах хүчний дутагдалтай байна гэж хэлээд, орон нутагт чиглэсэн ипотекийн зээл болон Улаанбаатар хотоос орон нутагт шилжиж суурьшиж байгаа иргэдэд зориулсан тусгай хөтөлбөр хөнгөлөлттэй орон сууцны зээлүүдийг 2023 оноос авч хэрэгжүүлээд энэ хүрээ дээр бол бас нэлээн амжилт олж байгаа. Бид яах вэ, 2025 оны төсөв дээр цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээс 30-аад мянган ажлын байр бол улсын хэмжээгээр нэмэгдэнэ гэж ингэж тооцсон. Саяын хэлдэг арга хэмжээнүүдээс гадна бид 1 хувийн татвар гэдгийг сая төсвийн тодотголоор хамт бол батлагдсан. Энэ тухайн төрлийн аж ахуйн нэгжүүд одоо бид бүх юмыг бол бид нар улсын төсвөөр бол хийгээд байх боломжгүй. Ямар нэгэн биеийн тамир, спорт болон ойжуулалт энэ тэр гээд тодорхой чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг бид нар бол 1 хувийн татварын бодлогоор бол дэмжиж

байгаа. Энэ бол өөрөөр хэлбэл саяын хэлсэн салбарууд дээр хувийн хэвшлийн зүгээс хөрөнгө оруулалт хийх юм бол энэ дээр 1 хувийн татварын бодлого хэрэгжүүлэх байдлаар бол ингэж орон нутгийн бас бие даасан байдлуудыг бол нэмэгдүүлж бол ингэж бол ирсэн байгаа.

Оюутолгойтой холбоотой асуудал бол бас олон.../минут дуусав/

С.Ганбаатар: 2 дугаар микрофоныг нээж өгье. Нэмэлт минут.

Ж.Ганбат: Оюутолгой дээр бол олон жил маргаантай явж ирсэн. Бид бол энэ дээр нэг л зүйлийг би бол энд шулуухан хэлэх гэж байна. Бид бол Оюутолгойг хянах ёстой. Энэ бол Монгол Улсын 34 хувийг бол бид эзэмшиж байгаа. Энэ утгаараа тэр Оюутолгой руу оруулж байгаа хөрөнгө оруулалтын зардлуудыг бид хянах ёстой. Энэ дээр бол Эрдэнэс Оюутолгой гэдэг компанийг бол эхэлж байгуулахдаа гол байгуулсан шалтгаан чинь бол Монгол Улсын Засгийн газрын тэр 34 хувийн хяналтаа тавих гэж л Эрдэнэс Оюутолгой гэдэг компанийг байгуулсан шүү дээ. Энэ компани бол тэр Монгол Улсын 34 хувь дээр нь бол зардлын зөвлөл дээр нэг хяналт тавина. Сангийн яам бол Оюутолгой компанийг татвараа бүрэн төлж байна уу, төлөхгүй байна уу. Монгол Улсын хуулийн дагуу төлөх ёстой татвараа төлж байна уу, төлөхгүй байна гэдэг дээр нь бол бид гол хяналтаа тавиад ингээд явж байгаа. Тэр зээл авч байгаа асуудлууд дээр бол би юу гэж хэлэх гээд энэ Эрдэнэ Оюутолгойд ярьж байна гэхээр.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд.

Ц.Туваан: Байнгын хорооны даргын асуултуудад хариулъя. Хүнд үйлдвэр, хөнгөн үйлдвэр гээд одоо Засгийн газарт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байгаа. Энэ дээр бол хөнгөн үйлдвэрийн асуудлууд, хүнсний үйлдвэрийн асуудлууд, жижиг, дунд

үйлдвэрийн асуудлууд харьяалагдаж байгаа. Бусад үйлдвэртэй холбоотой асуудал бол аж үйлдвэрийн гэдэг утгаараа бас манай яаманд харьяалагдаж байгаа гэдгийг хэлье. Өнгөрсөн хугацаанд бас Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо руу Засгийн газраас тухайлбал 2021 оны 11 сард Засгийн газраас Хүнд үйлдвэрийн тухай хууль ороод, Байнгын хороон дээрээс ингээд хэлэлцэгдэж байгаад буцсан байдаг. Тэгэхээр одоо хүнд үйлдвэрийн хуулийн асуудал бол Улсын Их Хурлын болон Байнгын хорооны бүрэн эрхэд байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Дээрээс нь үйлдвэрийн асуудал бол манай.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайдад 1 минут өгье. Тэгээд хүнд үйлдвэрийн хуулийг оруулаад ирчихсэн. Бид нар гацаагаад байгаа гэсэн санаа ярьчихсан уу.

Ц.Туваан: Үгүй ээ, үгүй. Оруулж ирээд тэгээд өмнөх парламентын Байнгын хороон дээрээс ингээд Засгийн газар луу буцаачихсан юм байгаа юм байна лээ. Тэрийг л хэлсэн юм. Тэрнээс Байнгын хороо дээр бол биш. Үйлдвэр технологийн паркийн хууль гээд хууль мөрдөгдөөд явж байгаа. Тэгээд энэ хууль бол энэ төр, хувийн хэвшлийн үйлдвэр технологийн паркуудын харилцааг зохицуулаад явах зориулалттай ийм хууль. Тэгэхээр энэ хуулийн хүрээнд бас асуудлуудаа шийдээд явах боломжтой. Мөн яах вэ тодорхой хэдэн журмуудыг бас бид нар нэмж батлах ийм шаардлагатай байгаа гэдгийг хэлье.

Газрын тосны бүтээгдэхүүн дээр бол 96 хувь ОХУ-аас хараат байгаа. Тэгээд энэ дээр бид нар бас үүнээс хараат бус болохын төлөө буюу 55 хувиа дотоодоосоо хангах энэ асуудлыг ярьж байгаа. Мөн БНХАУ өмнөд хөршөөсөө тодорхой хувийн ялангуяа.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд нөгөө экспорт нүүрснээс л ганцхан хараат улс болчихоод байна шүү дээ. Тэр дээр л.

Ц.Туваан: Тэгээд БНХАУ-аас бас нефтийн бүтээгдэхүүн импортлох асуудлыг ялангуяа энэ Евро 5 ангиллын чанар сайтай бүтээгдэхүүн импортолж авах асуудлыг бас цааш нь яриад явна. Нүүрс дээр бол энэ жилийн гүйцэтгэл бараг 80 гаруй сая тоннд хүрнэ. Энэ экспортыг бас илүү улам өргөтгөх ийм бодлого барьж явна. Яагаад вэ гэхээр тодорхой хэмжээнд 2030, 2035 оноос эхлээд нүүрсний хэрэглээ манай өмнөд хөрш дээр гэхэд л тооцоо судалгаагаар 35-40 хувиар буурч ирэх ийм судалгаанууд байгаа. Тэгэхээр үүнээс өмнө бас бид бүхэн 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ бодитойгоор 10 мянган доллароос дээш гаргахын тулд энэ уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний экспортоо хийнэ гэдэг ийм бодлогыг саяхан Засгийн газар дээр гаргаад.../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд 42.1 болон цахилгаан, дулаан бол энэ үйлдвэрлэгч тал дээр.

Ц.Туваан: Энэ эрчим хүчтэй холбоотой асуудлыг Эрчим хүчний яам хариулсан нь зөв байх. Оюутолгойтой холбоотой асуудал дээр бол мэдээж сая Ганбат Төрийн нарийн бичгийн дарга хэлсэн. Энэ дээр Улсын Их Хурлын тогтоол байгаа. 6 зүйл, заалттай 103 дугаар тогтоол. Үүний бас хэрэгжилтийн асуудал, гүйцэтгэлийн хэдэн хувьтай энэ даалгаврын биелэлтийн асуудал бол бас танилцуулагдахаар байгаа гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хуулиас эхэлье. Хөнгөн үйлдвэрийн тухай хууль төсөл бэлэн болчихсон байгаа. Өргөн барихад бэлэн байна. Бид шинэ Байнгын хороо маань ингээд үйл ажиллагаа нь эхэлж байна. Байнгын хорооныхоо гишүүддээ ер нь

хөнгөн, хүнсний үйлдвэрийнхээ энэ салбартай танилцах ажлыг зохион байгуулах зүйтэй болов уу гэж бодож байгаа. Тэгээд үйлдвэрүүд дээр явъя. Яг салбарын нөхцөл байдалтай танилцсаны дараа төсөл дээрээ ажиллаад бүгдээрээ хамтдаа өргөн бариад, шийдэх талаасаа явцгаая гэж бодож байна.

Мэдээж салбарт хийгдэх ажлууд их байгаа. Тэгээд Байнгын хороотойгоо их нягт ажиллана. Өөр арга байхгүй. Бид Засгийн газрын 2028 он хүртэл хэрэгжих мөрийн хөтөлбөр маань үйл ажиллагааны хөтөлбөр маань үндсэндээ батлагдчихсан. Тэр хүрээнд бид нар бүх төлөвлөлт тооцоогоо хийгээд ирлээ. 4 том хөтөлбөр тодорхой болсон. Энэ хүрээ дотор л бид нар эрэмбээ тогтоогоод л, тэргүүлэх чиглэлүүдээ гаргаад цаашидаа явна. Энэ бүх ажлаа Байнгын хороотойгоо уялдаад явах ёстой. Байнгын хорооны дэмжлэггүйгээр бас явахгүй нь тодорхой байгаа.

С.Ганбаатар: Энхбаяр сайдад нэмэлт 1 минут.

Ж.Энхбаяр: Хамгийн гол нь дотоодын бүтээгдэхүүний 30.8 хувийг үйлдвэрлэж байгаа. Ажиллах хүчний 2 хүний 1. 600 мянган ажлын байрыг хадгалж байгаа энэ салбарын тогтвортой байдлыг хангах онцгой чухал байна. Ажлын байрыг алдахгүй тогтворжуулах нь их чухал. Мэдээж бид нар экспортын том зорилттой ажиллаж байна. Зөвхөн 1 жилийн хугацаанд гэхэд бид 1 их наяд төгрөгийн экспорт нэмж чадсан. Нөгөө талаасаа импортыг хааж байгаа. 260 тэрбумын импортыг багасгасан. Нийт хөнгөн хүнсний үйлдвэр маань 3,5 их наядын үйлдвэрлэл явуулаад, 4,7 их наядын борлуулалт хийсэн. Энэ хүрээнд л энэ олон ажиллах ажлын байр, баялгийн хуваарилалтууд ингээд явж байгаа. Мэдээж бүхий л түвшинд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, экспорт буюу валютын нөөцийг эх орондоо бий болгох, ажлын байрыг хадгалах ийм л зорилгын

хүрээнд үйл ажиллагаа нь чиглэж байна. Тэгээд үр дүн гарна.

С.Ганбаатар: Тавинбэх сайд.

Н.Тавинбэх: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын хувьд эрчим хүчний үнэ тариф нэмдэг олон улсын жишигт нийцсэн бүтэц, эрх зүйн орчинтой. Маш сайн бүтэц орчинтой гэж ингэж дүгнэдэг. Харамсалтай нь энэ эрх зүйн орчныг, энэ бүтцийг ажиллуулахгүй, ажиллахгүй, ажиллуулахгүй байгаад л учир байгаа. Тийм ч учраас өнөөдөр үнэ тарифтай холбоотой асуудал маш хүнд нөхцөл байдалтай болсон. Эрчим хүчний зохицуулах хороо хараат бусаар эрчим хүчний бизнес эрхлэгчдийн шаардлага, хүсэлт, тооцооллоос гадна хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж үнэ тарифын өөрчлөлтийг хийдэг л ийм л учиртай. Саяын таны асуудаг асуултад бол энэ цаг үед Эрчим хүчний зохицуулах хороо л хариулах ёстой. Бусад газрууд оролцох ёсгүй.

С.Ганбаатар: Ингээд төсөвтэй холбоотой асуултад асууж дууслаа. Хариулт авлаа. Ингээд өнөөдөр бол Улсын Их Хурлын Байнгын хороогоор бас ярих асуудлууд нэлээн овоорсон байгаа. Тэгээд тэрийг дараа нь гишүүдтэйгээ бас бид ярилцах юм байгаа юм. Тэгээд хамгийн гол нь хариултад бол хангалтгүй байлаа. Тэрийгээ та нар бас бичгээр гишүүдэд хандаж өгнө гэж би ойлгож байна.

2 санал гарсан. Тэр газрын тосны үйлдвэртэй холбоотой асуулга, хэлэлцүүлгийг яаралтай хийе гээд ярьсан. Бас Энхтуяа гишүүн ярьсан шүү. Тэр Тавантолгойн нүүрсний түлшний үйлдвэрийн талаар бас асуулга тавьсан. Ойрын үед энийг бэлтгэл ажлыг нь хангуулж хийхээр боллоо.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5-д заасны дагуу байнгын

хорооны хуралдаанд гишүүн нам, эвслийн бүлэг, төрийн аудитын байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналаа хамт гаргана гэж заасан. 39.14-д гишүүд энэ дээр бас анхаараарай. Зарчмын зөрүүтэй саналаа хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлж байна гэж энэ шинэ хууль энэ өнгөрсөн 4 сард батлагдсан 4, 5 сард батлагдсан байх шүү. Тэгээд дээрх хуулийн холбогдох заалтын дагуу Байнгын хороонд гишүүдээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар санал ирээгүй байна.

Ингээд төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

16.09 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Э.СУВД-ЭРДЭНЭ